Mongolian Marketing Consulting Group

YOUR RESEARCH PARTNER

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ ТАВИХ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДҮҮДИЙН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2019.12.13

Захиалагч: Санхүүгийн зохицуулах хороо

Зөвлөх: “Эм Эм Си Жи” ХХК

ESOMAR'19 corporate

CTRQ ISO 20252 CERTIFIED RESEARCH STANDARD

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ ТАВИХ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДҮҮДИЙН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ЭМ ЭМ СИ ЖИ ХХК
Зүүн хүрээ хотхон, 203-р байр, 4 давхар, 14-р хороо
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар,
Монгол Улс
Утас/Факс: 976-77000188
Мэйл: info@mmcg.mn
Веб сайт: http://www.mmcg.mn

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
Монгол Улс, Улаанбаатар хот 15160,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, 3Г-ын IV байр
Утас: (976)-51-262789
Факс: (976)-11-329084
Веб сайт: http://www.frc.mn/

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР 5

ХУРААНГУЙ ҮР ДҮН 6

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ДАХЬ МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 12

БҮЛЭГ 2. СЭҮ-НИЙ АРГАЧЛАЛ 15

БҮЛЭГ 3. ЭРСДЭЛИЙН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС 22

БҮЛЭГ 4. АНХААРАХ ЗҮЙЛС 25

БҮЛЭГ 5. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТОХИОЛДЛУУД 27

5.1 Мөнгө угаах үе шатууд 27

5.2 Суурь гэмт хэргүүд, тэдгээрийн нөхцөл байдал 27

БҮЛЭГ 6. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ 31

БҮЛЭГ 7. ЭНЭХҮҮ ТАЙЛАН ДАХЬ ТОО МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ТАЙЛБАРЛАХ ВЭ 38

БҮЛЭГ 8. САЛБАР БҮРИЙН МУТС ЭРСДЭЛ 40

8.1 Банк бус санхүүгийн байгууллага 42

8.1.1. Зээлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ 47

8.1.2. Факторингийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ 52

8.1.3. Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэгч ББСБ 55

8.1.4. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ эрхлэгч ББСБ 58

8.1.5. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгч ББСБ 59

8.1.6. Гадаад валютын арилжаа эрхлэгч ББСБ 63

8.1.7. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ 68

8.1.8. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ эрхлэгч ББСБ 72

8.1.9. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ эрхлэгч ББСБ 75

8.2 Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч ..... **Error! Bookmark not defined.**

8.2.1. Ердийн даатгалын компани ..... **Error! Bookmark not defined.**

8.2.2. Урт хугацааны даатгалын компани ..... **Error! Bookmark not defined.**

8.2.3. Давхар даатгалын компани ..... **Error! Bookmark not defined.**

8.2.4. Даатгалын зуучлагч компани ..... **Error! Bookmark not defined.**

8.2.5. Даатгалын хохирол үнэлэгч ..... **Error! Bookmark not defined.**

8.3 Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд **Error! Bookmark not defined.**

8.3.1. ҮЦ-ны брокерын компани ..... **Error! Bookmark not defined.**

8.3.2. ҮЦ-ны дилерийн компани ..... **Error! Bookmark not defined.**

8.3.3. ҮЦ-ны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.4. ҮЦ-ны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.5. Андеррайтерийн үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.6. ҮЦ-ны өмчлөх эрхийн бүртгэлийн болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.7. ҮЦ-ны арилжааны тооцооны болон төлбөрийн үйл ажиллагаа **Error! Bookmark not defined.**

8.3.8. Кастодианы үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.9. ҮЦ-ны арилжаа эрхлэх үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.10. Хөрөнгө оруулалтын сан ..... **Error! Bookmark not defined.**

8.3.11. Хөрөнгө оруулалтын менежментийн компани ..... **Error! Bookmark not defined.**

8.3.12. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.3.13. ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн, хөрөнгийн үнэлгээний, аудитын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.4 Хадгаламж зээлийн хоршоо ..... **Error! Bookmark not defined.**

8.4.1. ХЗХ-ны хадгаламж зээлийн үйл ажиллагаа ..... **Error! Bookmark not defined.**

8.5 Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага ..... **Error! Bookmark not defined.**

8.5.1. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага ..... **Error! Bookmark not defined.**

8.5.2. Үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэгч ..... **Error! Bookmark not defined.**

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААН	Аж ахуйн нэгж
АНДББ	Ази, Номхон далайн бүсийн байгууллага
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
МУ	Мөнгө угаах
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МэҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБАЗ	Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл
СБ	Санхүүгийн байгууллага
СББМҮЭ	Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч нар
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
СЭҮ	Салбарын эрсдэлийн үнэлгээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТС	Терроризмыг санхүүжүүлэх
УИХ	Улсын Их Хурал
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЭҮ	Үндэсний эрсдэлийн үнэлгээ
ҮЦ	Үнэт цаас
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх олон улсын байгууллага /Financial Action Task Force - FATF/
ФТБНБ	ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагууд
ХАЗ	Хамтын ажиллагааны зөвлөл
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХҮТ	Харилцан үнэлгээний тайлан
ЭСАЗ	Эрсдэлд суурилсан арга зүй

ХУРААНГУЙ ҮР ДҮН

Үндэслэл: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хуулийн 19.1-д тухайн хуулийн 4.1.2-4.1.7-д заасан этгээд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хяналт тавьж ажиллах этгээдэд дараах этгээдийг хамруулан авч үзнэ. Үүнд:

1. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) (хуулийн 4.1.2);
2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч (хуулийн 4.1.3);
3. Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани (хуулийн 4.1.4);
4. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага (хуулийн 4.1.5);
5. Хадгаламж, зээлийн хоршоо (хуулийн 4.1.6);
6. Харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага (хуулийн 4.1.7).

Салбарын эрсдэлийн үнэлгээ (СЭҮ) нь салбар бүр дэх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС) эрсдэлийг ойлгоход СЗХ болон мэдээлэх үүрэгтэй этгээд (МэҮЭ)-үүдэд тусалдаг. Энэхүү салбарын эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулахдаа 2016 онд хийсэн Монгол Улсын МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ), 2017 онд хийсэн Харилцан үнэлгээний тайлан, Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх олон улсын байгууллага (Financial Action Task Force буюу FATF, цаашид "ФАТФ" гэх)-аас эдгээр салбаруудтай холбоотой гаргасан аргачлал, тайлан болон холбогдох бусад мэдээллийг авч үзсэн болно.

Салбарын эрсдэлийн үнэлгээг дараахь 2 байдлаар хийсэн. Үүнд:

- **Салбарын "төрөлхийн" эрсдэлийн үнэлгээ.** Тухайн салбарын үйл ажиллагааны цар хүрээ, салбарын хэмжээ, МэҮЭ-үүдийн идэвхжил зэргийг үл харгалзан салбар тус бүрийн үйл ажиллагааны онцлог, үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн байдал зэргийг харгалзан тодорхойлсон "төрөлхийн" эрсдэлийн үнэлгээ.
- **Салбарын эрсдэлийн өнөөгийн түвшин.** Тухайн салбарын үйл ажиллагааны цар хүрээ, салбарын хэмжээ, МэҮЭ-үүдийн идэвхжил зэргийг харгалзан тодорхойлсон тухайн салбарт МУТС магадлал (likelihood) болон МУТС үйлдлийн тухайн салбар, байгууллагад үзүүлэх санхүү-эдийн засгийн болон нэр хүнд, итгэлцлийн үр нөлөөний түвшингээр илэрхийлсэн салбарын эрсдэлийн өнөөгийн түвшин.

Салбарын "төрөлхийн" эрсдэлийн үнэлгээ. Салбар бүрийг дараах дөрвөн эрсдэлийн үнэлгээний онооны аль нэгээр тодорхойлсон. Оноо МУТС "төрөлхийн" эрсдэл (inherent risk)-

ийн үнэлгээн дээр үндэслэсэн. Эдгээр оноо нь МэҮЭ-үүд МУТС эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж хяналт, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэхгүй.

Бага | Дунджаас доош | Дунджаас дээш | Өндөр

Мэдээллийн бэлэн байдлаас шалтгаалан энэ удаагийн эрсдэлийн үнэлгээ нь тодорхой хязгаарлалттай байгаа бөгөөд цаашид мэдээллийн бэлэн байдлыг нэмэгдүүлснээр илүү үр нарийвчилсан үр дүн, дүгнэлтийг хийх боломжтой болно. СЗХ-ны хяналт тавих 5 салбарын эрсдэлийн үнэлгээний дүр зургийг доор харуулав.

Салбарууд	Салбарын эрсдэл 2019
Банк бус санхүүгийн байгууллага	Өндөр
Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид	Дунджаас доош
ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллагууд	Дунджаас дээш
Хадгаламж, зээлийн хоршоо	Бага
Үл хөдлөх хөрөнгө зуучлал	Өндөр

Салбарын эрсдэлийн өнөөгийн түвшин. Салбарын эрсдэлийн өнөөгийн түвшинг тодорхойлохдоо эхлээд тухайн салбарт МУТС эрсдэл тохиолдох магадлал (аюул занал болон эмзэг байдал)-ыг тодорхойлсон. Магадлалыг үнэлэхдээ төрөлхийн эрсдэлийн үнэлгээ болон салбарын хэмжээ, эргэлдэж буй хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагаа явуулж буй нэгжийн тоо зэрэг үзүүлэлтийг харгалзан дараахь хүчин зүйлсийг авч үзсэн.

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлал өндөр (5)	Магадлал бага (1)
Салбарын хэмжээ	Олон тооны байгууллага ажилладаг Өндөр эрсдэлтэй улс оронд үйл ажиллагаа явуулдаг олон байгууллага байдаг	Цөөн эсвэл жижиг байгууллагууд ажилладаг Байгууллагууд нь зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулдаг
Бүтээгдэхүүн үйлчилгээ	Бэлэн мөнгөөр төлбөр нь хийгддэг бүтээгдэхүүн, гүйлгээний тоо олон Нарийн төвөгтэй бүтээгдэхүүнтэй Сангийн эх үүсвэр нь үргэлж тодорхой бус байдаг	Бэлэн мөнгөөр төлбөр нь хийгддэг бүтээгдэхүүн, гүйлгээний тоо хязгаарлагдмал эсвэл цөөн Энгийн бүтээгдэхүүнтэй Сангийн эх үүсвэр нь тодорхой
Гүйлгээ	Өндөр дүнтэй гүйлгээ хийгддэг Өндөр эрсдэлтэй улс оронд байгаа харилцагч руу хийсэн гүйлгээний тоо олон	Бага дүнтэй гүйлгээ хийгддэг Зөвхөн дотоодод гүйлгээ хийгддэг
Харилцагч	Гадаад улсын болон хөрөнгө ихтэй харилцагчид олонтой Нарийн төвөгтэй бүтэцтэй олон тооны харилцагчидтай	Зөвхөн дотоодын харилцагчидтай
Хүргэх суваг	Харилцагчтай хэзээ ч нүүр тулж харилцдаггүй	Харилцагчтай шууд харилцдаг

Үүний дараа тухайн салбарт МУТС эрсдэл тулгарсан үед тухайн салбарт үүсч болох үр нөлөөг санхүү-эдийн засгийн үр нөлөө, салбарын нэр хүндэд үзүүлэх үр нөлөөгөөр (1 "үр нөлөө багатай" – 5 "үр нөлөө өндөртэй") үнэлсэн.

Тухайн салбар, үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг эрсдэл үүсэх магадлал болон эрсдэлийн үр нөлөөний үржвэр байдлаар тодорхойлсон.

Салбаруудын эрсдэлийн өнөөгийн түвшин



Салбаруудын эрсдэлийн зураглал



СЭҮ-ний зорилго: Энэхүү СЭҮ-ний зорилго нь СЗХ-ны хяналт тавьж ажиллах 5 салбар дахь МэҮЭ-үүдэд тулгарч болох МУТС эрсдэлийг тодорхойлох явдал юм. Эрсдэлийг тодорхойлох нь МУТСТ эхний алхам юм. Уг үе шат нь эрсдэлд суурилсан арга зүй (ЭСАЗ)-г хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг дагаж мөрдөх нөөцийг үр дүнтэй хуваарилах эхний алхам болдог. Энэхүү СЭҮ-г дараахь талууд авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. **МэҮЭ-үүд:** МэҮЭ-үүд өөрсдийн эрсдэлийн үнэлгээг хийх, шинэчлэхдээ энэхүү СЭҮ-г авч үзэх шаардлагатай.
2. **СЗХ:** Хяналт тавьж буй салбар бүрийн эрсдэлийг үнэлснээр хязгаарлагдмал төсвөө үр дүнтэй хуваарилах боломжтой болно.
3. **Үндэсний зөвлөл, Санхүүгийн мэдээллийн алба (СМА) болон бусад хууль сахиулах эрх бүхий байгууллага:** Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)-нд орох дүгнэлт мэдээллийг бий болгох, Монгол банк болон бусад байгууллагыг мэдээллээр хангах.
4. **Бусад байгууллага:** ФАТФ-ын зөвлөмжийн дагуу улс орнууд МУТСТ хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх ёстой бөгөөд энэхүү СЭҮ нь энэ үүргээ биелүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

Энэ удаагийн СЭҮ-ний онцлог: МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4.1.2-4.1.7-д заасан МэҮЭ-үүдийн салбарын МУТС эрсдэлийн үнэлгээг СЗХ-ноос анх удаа гаргаж байна. Салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг гаргахдаа 2016 онд гаргасан ҮЭҮ, Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-аас 2017 онд хийсэн Харилцан үнэлгээний тайлан, ФАТФ-аас гаргасан салбаруудын ЭСАЗ-н удирдамж, салбаруудын 2018 оны болон 2019 оны статистик мэдээлэлд үндэслэн энэхүү үнэлгээг хийлээ.

МэҮЭ-үүд СЭҮ-г хэрхэн ашиглах хэрэгтэй вэ:

- Бүлэг 1-7-г авч үзэх
- Харьяалах салбар, эрхэлж буй үйл ажиллагааны талаарх бүлэг, хэсгийг авч үзэх
- Өөрсдийн эрсдэлийн үнэлгээг дахин авч үзэж шинэчлэх.

Бүх МэҮЭ энэхүү СЭҮ-ний Бүлэг 1-7-г авч үзсэнээр СЭҮ-ний хамрах хүрээ, хязгаарлалтын талаар мэдээлэл авч, СЭҮ-г хэрхэн ашиглах талаарх ойлголттой болно.

Салбар, үйл ажиллагаа бүрт тулгарах "төрөлхийн" эрсдэл, анхаарах зүйлс (red flags), салбар, үйл ажиллагааны онцлог зэргийг хамруулсан тусгайлсан үнэлгээг 8 дугаар бүлэгт салбар бүрээр гаргасан. Тайланд бүх салбарт хамаарах нийтлэг анхаарах зүйлс болон салбар тус бүрт анхаарах зүйлсийг тодорхойлж өгсөн.

Тухайн нэг МэҮЭ нь салбарын дунджаас өөр өөр байх боловч тухайн чиглэлд байгууллагын эрсдэлийг бууруулах эсвэл нэмэгдүүлэх хэд хэдэн хүчин зүйлсийг тодорхойлж өгсөн байгаа болно. Энэ нь СЗХ-ноос тухайн салбарт өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон чиглэлүүдийг

ойлгоход туслах болно. "*Энэхүү тайлан дахь тоо мэдээллийг хэрхэн унших вэ*" гэсэн гарчигтай 7 дугаар бүлгээс илүү дэлгэрэнгүй танилцана уу.

Хэрэв нэгээс дээш салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бол холбогдох бүх эрсдэлийн үнэлгээг авч үзэж, ашиглах хэрэгтэй. Ерөнхий эрсдэл нь тодорхойлсон МУТС эрсдэл, салбар дотроо хэчнээн үйл ажиллагааг эрхэлж байгаа зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна.

МэҮЭ нь энэхүү СЭҮ-нд тодорхойлсон аливаа эрсдэлийг өөрсдийн эрсдэлийн үнэлгээндээ авч үзэж, шинэчлэх шаардлагатай. Тухайлбал, эрсдэлийн үнэлгээг жил бүр хянан үзэхдээ авч үзэх, тодорхой үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх зэргээр СЭҮ-г ашиглана.

СЗХ-ноос хийх хяналт шалгалтын хүрээнд СЭҮ-нд тодорхойлсон зүйлсийг хэрхэн авч үзэж, МУТСТ тухай хуулийн 4.3-д заасны дагуу МУТСТ үйл ажиллагааг эрсдэлд суурилсан арга хэлбэрээр хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих болно. МэҮэ нь боломжит МУТС үйлдлийг үр дүнтэй удирдаж байгаа эсэхийг хянах бодлого, дүрэм журам, хяналтын тогтолцоогоо энэхүү СЭҮ-тэй нийцүүлэх хэрэгтэй.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ДАХЬ МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас анх 2006 оны 07 дугаар сарын 8-ны өдөр батлан гаргасан. Уг хуульд 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулж, 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар шинэчлэн найруулж, 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан.

МУТСТ тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "...энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7, 4.1.8-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо ...эрсдэлд суурилсан суурилсан хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэж заасан.

МУТСТ тухай хуулийн 2 дугаар бүлэгт МУТС-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр МэҮЭ болон тэдгээрийн төрийн байгууллагатай харилцах харилцааг зааж өгсөн бөгөөд уг хуулийн 3 дугаар бүлэгт эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тодорхойлж өгсөн. Хуулийн 19.2-д зааснаар СЗХ нь МэҮЭ-үүдийн салбарын эрсдэлийн үнэлгээг хийж, салбарын МэҮЭ-үүдэд мэдээлэл, зөвлөмж өгөх үүргийг хүлээсэн байдаг.

ФАТФ-ын зөвлөмж болон олон улсын туршлагаас авч үзэхэд МУТС эрсдэлийг өөр өөр өнцгөөс нь авч үзсэн эрсдэлийн үнэлгээний гурван түвшинд авч үзсэн байдаг. Эдгээр гурван үнэлгээ нь хамтдаа МУТСТ-д туслах боломжит эрсдэлийн талаарх мэдээллийг төр засаг, эрх бүхий байгууллага, МэҮЭ-үүдэд өгдөг. Гурван эрсдэлийн үнэлгээг хослуулснаар тухайн улсад тулгарч буй МУТС эрсдэлийн дүр зургийг харуулдаг. Эдгээр гурван үнэлгээ нь хэрхэн бие биедээ мэдээлэл өгдгийг дараах зургаар харуулав (Зураг 1). Эрсдэлийн үнэлгээний гурван түвшин нь:

Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)

ҮЭҮ нь Монгол Улсад бүхэлд нь нөлөөлж буй МУТС асуудлыг авч үзнэ. Энэ нь сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) болон бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл дээр үндэслэдэг. Дотоодын болон олон улсын аль алиных нь төрийн байгууллагаас гаргасан мэдээлэл нь мөн ҮЭҮ-нд ашиглагдах бөгөөд аюул занал, гэмт хэргийн хандлагын өргөн хүрээтэй дүр зургийг харуулдаг. МэҮЭ-үүд ҮЭҮ-г ашиглан тулгарч буй аюул занал, хандлагын талаар мэдээлэлтэй болох ёстой. СЗХ болон бусад эрх бүхий байгууллагуудын МУТСТ сургалт хариуцсан ажилтнууд холбогдох кэйс судалгаа, бүртгэгдсэн хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг сургалт, сурталчилгааны ажилдаа ашиглах хэрэгтэй. Олон улсын туршлагаас харахад МУТС-д хүргэдэг гэмт хэргийн мөн чанарыг ойлгосон ажилтнууд МУТС үйлдлийг олж илрүүлэх, таслан зогсоох хүсэл эрмэлзэл өндөртэй байдаг болохыг олж тогтоожээ.

Салбарын эрсдэлийн үнэлгээ (СЭҮ)

МУТСТ эрх бүхий байгууллагууд нь хариуцсан салбаруудынхаа эрсдэлийн үнэлгээг гаргадаг. Эдгээр байгууллагаас гаргах МУТС салбарын эрсдэлийн үнэлгээ нь тухайн салбарт үйл

ажиллагаа явуулж байгаа МэҮЭ-үүдийн ойлголтыг сайжруулах, эрсдэлийн үзүүлэлтүүд, хандлага, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл өгөх зорилготой. СЗХ-ноос гаргаж буй энэхүү СЭҮ нь МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4.1.2-4.1.7-д заасан МэҮЭ-ийн 5 салбарт МУТС эрсдэл хэрхэн нөлөөлж байгааг салбарын түвшинд авч үзнэ.

МэҮЭ тус бүрийн эрсдэлийн үнэлгээ (МэҮЭ-үүдээрх ЭҮ)

МэҮЭ-үүдээрх эрсдэлийн үнэлгээ нь дараах 2 хэлбэртэй байна. Үүнд:

1. МэҮЭ-үүдийн МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх МэҮЭ-ийн МУТС эрсдэлийн өөрийн үнэлгээ;
2. Эрх бүхий байгууллагаас МэҮЭ-ийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих зорилгоор тогтмол хугацааны давтамжтай хэрэгжүүлэх МэҮЭ тус бүрийн МУТС эрсдэлийн үнэлгээ.

МэҮЭ-ийн МУТС эрсдэлийн өөрийн үнэлгээ: Мэдээлэх үүрэгтэй этгээд (МэҮЭ)-үүд нь өөрсдийн бизнестээ МУТС эрсдэлийн үнэлгээг хийх ёстой. МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д МэҮЭ-үүд МУТСТ үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ гэж заасан. Үүнд:

1. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;
2. Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл;
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;
4. Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.14-д МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг холбогдох эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална гэж заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 тоот тушаалаар "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-ыг батлан гаргасан байдаг. Салбарын МэҮЭ-үүд МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дээрх хуулийн заалт болон журмыг дагаж мөрдөх шаардлагатай.

МэҮЭ-үүд нь МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмаа боловсруулахдаа холбогдох СЭҮ болон МУТСТ олон улсын байгууллагууд, ялангуяа ФАФТ болон АНДББ-ын гаргасан гарын авлага, удирдамжийг ашиглах хэрэгтэй.

СЗХ-ноос тогтмол хугацааны давтамжтай, МэҮЭ тус бүрээр хийх МУТС эрсдэлийн үнэлгээ: МУТСТ тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д зааснаар СЗХ нь холбогдох МэҮЭ-үүдэд хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, зайнаас хяналт тавих, газар дээрх шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах үүрэгтэй. Уг заалтын дагуу СЗХ нь холбогдох МэҮЭ-үүдийн СЗХ-нд ирүүлсэн мэдээлэлд үндэслэн МэҮЭ тус бүрээр МУТС эрсдэлийн үнэлгээг тогтмол хугацааны давтамжтай хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. МУТС эрсдэлийн үнэлгээний эрсдэлийн оноо өндөр гарахад нөлөөлсөн хүчин зүйлсийн талаарх тайлбар, тодруулга авах;
2. МУТС эрсдэлт хүчин зүйлсэд хяналт тавьж ажиллах талаарх холбогдох МэҮЭ-д заавар, зөвлөмж хүргүүлэх;
3. Шаардлагатай тохиолдолд санууллга өгөх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Тухайлбал, тухайн МэҮЭ-ийг газар дээрх шалгалтад хамруулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Зураг 1: МУТС эрсдэлийн үнэлгээнүүдийн харилцан хамаарал



БҮЛЭГ 2. СЭҮ-НИЙ АРГАЧЛАЛ

СЭҮ-ний үндэслэл: СЭҮ-нд дараах мэдээллийг ашигласан:

- Монгол Улсын Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон Харилцан үнэлгээний тайлан;
- Санхүүгийн зохицуулах хороон дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүртгэл мэдээлэл, сар, улирлын тайлан мэдээлэл;
- Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээдүүдэд хийсэн хяналт шалгалтын тайлан мэдээлэл;
- Хамтын ажиллагааны зөвлөл, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайлан;
- Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны статистик мэдээлэл;
- ФАТФ болон бүс нутгийн байгууллагаас гаргасан тухайн салбаруудын талаарх тайлан, типологи тайлан, эрсдэлд суурилсан арга зүйн удирдамж;
- Өмнө нь энэ чиглэлээр хийгдсэн үнэлгээний тайлан, мэдээлэл;
- Бусад байгууллагаас гаргасан судалгаа, тайлан мэдээлэл гэх мэт.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт болон холбогдох бусад заалтын дагуу салбар бүрийг дараах үзүүлэлтээр үнэлсэн:

- Харилцагч, тэдгээрээс хамаарч үүсэх нөхцөл;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх арга, хэлбэр;
- Газар зүйн байршил;
- Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа болон тодорхой төрлийн үйл ажиллагааг эрхэлж буй этгээдийн тоо, тэдгээрийн бүтэц зохион байгуулалтын хэлбэр;
- Тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, дүрэм журмын тоо, хамрах хүрээ;
- Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн хууль тогтоомжийг дагаж мөрдөж буй байдал, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын тоо, төрөл хэлбэр гэх мэт.

Хамрах хүрээ: Энэхүү салбарын эрсдэлийн үнэлгээний тайлангаар МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу СЗХ-ны хяналт тавьж ажиллах үг хуулийн 4.1.2-4.1.7-д заасан МэҮЭ-ийн дараах 5 салбарт МУТС эрсдэл хэрхэн нөлөөлж байгааг салбарын түвшинд авч үзнэ. Үүнд:

1. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ);
2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
3. Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани; үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага. Нийтэд нь "үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага" гэж тодорхойлов;
4. Хадгаламж зээлийн хоршоо;
5. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага.

ББСБ: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын хуулиар банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон гарах харилцааг зохицуулдаг. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг" ойлгоно гэж заасан байдаг.

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараах үйл ажиллагааг ойлгоно гэж заасан байдаг. Үүнд:

- зээл;
- факторингийн үйлчилгээ;
- төлбөрийн баталгаа гаргах;
- төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;
- цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ;
- гадаад валютын арилжаа;
- итгэлцлийн үйлчилгээ;
- богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
- хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг" ойлгоно гэж заасныг МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д заасан "банк бус санхүүгийн байгууллага" гэж үзэж ББСБ-ын МУТС эрсдэлийн үнэлгээнд хамрах хүрээ болгон авч үзсэн. "Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах" үйл ажиллагааны зохицуулалтыг 2017 онд батлагдсан Үндэсний төлбөрийн системийн тухай Монгол Улсын хуулийн дагуу Монголбанк хэрэгжүүлж байгаа хэдий ч салбарын эрсдэлийн үнэлгээнд хамруулан авч үзлээ. "Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа"-ны чиглэлээр СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан ББСБ одоогоор байхгүй учраас уг үйл ажиллагаа энэ удаагийн СЭҮ-нд оруулаагүй болно.

Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч: Даатгалын тухай Монгол Улсын хуулиар даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, даатгагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "даатгалын үйл ажиллагаа гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг" ойлгоно гэж заасан байдаг.

Даатгалын тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д "даатгагч гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг" ойлгоно, 3.3-д "Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн эрх зүйн байдлыг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулна" гэж заасныг МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан "даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч" гэж үзэж даатгалын салбарын МУТС эрсдэлийн үнэлгээнд хамрах хүрээ болгон авч үзнэ.

Даатгалын тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч этгээдийг хамруулж авч үзэж Даатгалын салбарын МУТС эрсдэлийн үнэлгээнд хамруулж авч үзсэн.

Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага: Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулиар үнэт цаасны зах зээл (ҮЦЗЗ)-д оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "үнэт цаасны зах зээл гэж үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх, гаргах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх, төлбөр, тооцоо гүйцэтгэх, хадгалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зохицуулалттай зах зээлийн болон биржийн бус зах зээлийн харилцааг" ойлгоно гэж заасан байдаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "үнэт цаасны зах зээлд оролцогч гэж үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээд болон хөрөнгө оруулагчийг" ойлгоно гэж заасныг МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан "үнэт заасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага" гэж үзэж салбарын эрсдэлийн үнэлгээнд хамруулж авч үзлээ. Үнэт цаасны зах зээлд оролцогчид болох үнэт цаас гаргагч - хөрөнгө оруулагчийг зохицуулалттай этгээдийн харилцагч үйлчлүүлэгч гэж үзсэн.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32-д "хөрөнгө оруулалтын сан гэж хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар энэ хуулийн 4.1.18-д заасан үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг", 4.1.33-д "хөрөнгө оруулалтын менежментийн компани гэж хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг" тус тус ойлгоно гэж заасныг МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан "хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани" гэж үзэж ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллагын салбарын эрсдэлийн үнэлгээнд хамруулан авч үзлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "зохицуулалттай этгээд гэж энэ хуулийн 24.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийг" ойлгоно гэж заажээ. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зохицуулалттай үйл ажиллагаанд дор дурдсан үйл ажиллагаа хамаарна.

24.1.1. үнэт цаасны брокерын;

24.1.2. үнэт цаасны дилерийн;
24.1.3. үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн;
24.1.4. үнэт цаасны итгэмжлэн удирдах;
24.1.5. андеррайтерийн;
24.1.6. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн;
24.1.7. үнэт цаасны арилжааны тооцооны;
24.1.8. үнэт цаасны арилжааны төлбөрийн;
24.1.9. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн;
24.1.10. кастодианы;
24.1.11. үнэт цаасны арилжаа эрхлэх;
24.1.12. хөрөнгө оруулалтын сангийн;
24.1.13. хөрөнгө оруулалтын менежментийн;
24.1.14. санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох;
24.1.15. үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх;
24.1.16. үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх;
24.1.17. үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх;
24.1.18. Хорооноос зохицуулалттай гэж тооцсон бусад.

Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д "Энэ хуулийн 24.1.1-24.1.14, 24.1.18-д заасан үйл ажиллагааг Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ", 24.3-д "Энэ хуулийн 24.1.15-24.1.17-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээд Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг ханган, Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрхэлнэ" гэж тус тус заасныг үндэслэн ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллагын салбарын эрсдэлийн үнэлгээнд хамруулан авч үзлээ.

Мөн хуулийн 24.4-д "Энэ хуулийн 24.1.14-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанктай зөвшилцсөнөөр Хороо олгоно" гэж заасан, одоогоор энэ чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан этгээд байхгүй хэдий ч "санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох" үйл ажиллагааг энэ удаагийн СЭҮ-нд хамруулсан.

Хадгаламж, зээлийн хоршоо: Хадгаламж, зээлийн хоршооны тухай Монгол Улсын хуулиар хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "хадгаламж, зээлийн хоршоо гэж гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг" ойлгоно гэж заасан байдаг.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр мөнгөн хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрхэлнэ", 13.5-д "Хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос зөвшөөрсөн, хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад ажил, үйлчилгээг эрхэлж болно" гэж тус тус заасан байдаг. Үүнтэй холбоотойгоор ХЗХ-ны мөнгөн хадгаламж, зээлийн болон СЗХ-ноос зөвшөөрсөн, хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад ажил, үйлчилгээг МУТСТ тухай Монгол Улсын

хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасан "хадгаламж, зээлийн хоршоо" гэж үзэж ХЗХ-ны МУТС эрсдэлийн үнэлгээнд хамрах хүрээ болгон авч үзсэн.

Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллага: МУТСТ тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага" МэҮЭ байна гэж заасан байдаг. Гэтэл үл хөдлөх хөрөнгийн зуучлагч нарын үйл ажиллагаа Монгол Улсад харьцангуй бага хөгжсөн бөгөөд зуучлагч нар харилцагчаас шууд бэлэн мөнгө хүлээн авдаггүй, тэдний хөрөнгийг захиран зарцуулдаггүй, түүнчлэн, барилгын компаниуд ихэвчлэн зуучлагч оролцуулалгүй өөрсдөө шууд борлуулалт хийдэг. Гэсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбарт дараах оролцогчид харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулж болох тул уг салбарын хамрах хүрээ болгон авч үзнэ. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага - худалдан авагч, худалдагч болон түрээслэгч, түрээслүүлэгч хоёрыг холбож өгч, хэлэлцээрт тэднийг төлөөлөн оролцож үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын үйл ажиллагааг зохицуулдаг этгээд;
2. Үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэгч - үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэх газрыг гаргах, чөлөөлөхөөс эхлүүлээд үл хөдлөх хөрөнгийг ашиглалтад оруулах хүртэлх бүхий л үйл явцыг удирдан явуулж буй, санхүүжүүлж, борлуулалтыг өөрөө хариуцан гүйцэтгэж буй этгээд. Төсөл хэрэгжүүлэгч төслийн үйл явц дахь бүхий л үе шатыг өөрөө гардан хэрэгжүүлсэн эсхүл тодорхой хэсэгт туслан гүйцэтгэгчтэй гэрээлэн төслийг хэрэгжүүлсэн байж болно.

Хязгаарлалт: Салбаруудыг харьцуулахад харилцан уялдаатай байдлыг хангахын тулд үүсч болох МУТС "төрөлхийн" (inherent) эрсдэлийг тодорхойлдог. Тухайн нэг МэҮЭ-д тулгарч буй эрсдэл нь тухайн МэҮЭ-ийн бизнесийн онцлог шинж чанараас шалтгаалан салбарын дунджаас хэлбэлзэж болно.

Эрсдэлийн хэмжээс: Салбарын эрсдэлийн үзүүлэлтүүдийн хувьд доорх эрсдэлийн хэмжээсийг ашигласан. Эрсдэлийн эрэмбийн тодорхой байршилд оруулахын тулд "дундаж" эрсдэлийн хэмжээсийг ашиглаагүй болно. Салбар бүрийн хувьд МУТС эрсдэлийг дараах байдлаар эрэмбэлсэн:

"Төрөлхийн" (inherent) эрсдэл: Хэрэв хяналт болон бусад бууруулах хүчин зүйлс байхгүй бол тухайн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл. СЭҮ-гээр салбарын МУТС төрөлхийн эрсдэлийг үнэлдэг. Тогтмол эрсдэл нь МэҮЭ-д аливаа хяналт байгаа эсэхийг үл харгалзан үздэг. Эдгээр нь МэҮЭ бүрт ихээхэн ялгаатай байж болох учраас ерөнхийд авч үздэг бөгөөд МУТС эрсдэлийг бууруулах боломжит нөөц болон хичээл зүтгэлээс шалтгаалдаг.

Эмзэг байдал: МУТС зорилгоор ашиглагдаж болох сул тал. Хяналт тавьж буй салбарын гол эмзэг байдлыг харгалзан үздэг. Энэ нь салбарын эрсдэл(үүд)-ийг тодорхойлоход тусалдаг. Үүнд:

- Нарийн төвөгтэй байдал (Complexity);
- Хөрвөх чадвар (Liquidity);
- Тодорхойгүй байдал (Anonymity).

МУТС эрсдэл тохиолдох түвшнийг тодорхойлохын тулд МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4.3-д заасан үзүүлэлт бүрээр салбар бүрийг нэг бүрчлэн үнэлдэг. Ерөнхий эрэмбэлэлт нь салбар дахь өндөр эрсдэлтэй хүчин зүйлсийн нөлөөллийн түвшинг харуулдаг. Эмзэг байдлын тоо, ялангуяа хүчтэй эмзэг байдлын тоо олон байвал МУТС эрсдэл өндөртэй гэж үзнэ.

тодорхойлохдоо эхлээд тухайн салбарт МУТС эрсдэл тохиолдох магадлал (аюул занал болон эмзэг байдал)-ыг тодорхойлсон. Магадлалыг үнэлэхдээ төрөлхийн эрсдэлийн үнэлгээ болон салбарын хэмжээ, эргэлдэж буй хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагаа явуулж буй нэгжийн тоо зэрэг үзүүлэлтийг харгалзан дараахь хүчин зүйлсийг авч үзсэн.

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлал өндөр (5)	Магадлал бага (1)
Салбарын хэмжээ	Олон тооны байгууллага ажилладаг Өндөр эрсдэлтэй улс оронд үйл ажиллагаа явуулдаг олон байгууллага байдаг	Цөөн эсвэл жижиг байгууллагууд ажилладаг Байгууллагууд нь зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулдаг
Бүтээгдэхүүн үйлчилгээ	Бэлэн мөнгөөр төлбөр нь хийгддэг бүтээгдэхүүн, гүйлгээний тоо олон Нарийн төвөгтэй бүтээгдэхүүнтэй Сангийн эх үүсвэр нь үргэлж тодорхой бус байдаг	Бэлэн мөнгөөр төлбөр нь хийгддэг бүтээгдэхүүн, гүйлгээний тоо хязгаарлагдмал эсвэл цөөн Энгийн бүтээгдэхүүнтэй Сангийн эх үүсвэр нь тодорхой
Гүйлгээ	Өндөр дүнтэй гүйлгээ хийгддэг Өндөр эрсдэлтэй улс оронд байгаа харилцагч руу хийсэн гүйлгээний тоо олон	Бага дүнтэй гүйлгээ хийгддэг Зөвхөн дотоодод гүйлгээ хийгддэг
Харилцагч	Гадаад улсын болон хөрөнгө ихтэй харилцагчид олонтой Нарийн төвөгтэй бүтэцтэй олон тооны харилцагчидтай	Зөвхөн дотоодын харилцагчидтай
Хүргэх суваг	Харилцагчтай хэзээ ч нүүр тулж харилцдаггүй	Харилцагчтай шууд харилцдаг

Үүний дараа тухайн салбарт МУТС эрсдэл тулгарсан үед тухайн салбарт үүсч болох үр нөлөөг санхүү-эдийн засгийн үр нөлөө, салбарын нэр хүндэд үзүүлэх үр нөлөөгөөр (1 "үр нөлөө багатай" – 5 "үр нөлөө өндөртэй") үнэлсэн.

Тухайн салбар, үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг эрсдэл үүсэх магадлал болон эрсдэлийн үр нөлөөний үржвэр байдлаар тодорхойлсон.

Эрсдэл үүсэх магадлал (аюул занал, эмзэг байдал)
Эрсдэлийн үр нөлөө
Эрсдэлийн түвшин

БҮЛЭГ 3. ЭРСДЭЛИЙН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Доорх эрсдэлийн гол хүчин зүйлс нь МУТС эмзэг байдлыг тодорхойлоход тусална. Эмзэг байдлын үзүүлэлтүүд нь тухайн эрсдэлийг нэмэгдүүлэх эсвэл бууруулах хүчин зүйлс гэсэн хоёр бүлэг хуваагдана. Энэ нь МЭҮЭ-үүдэд тэдний эрсдэл нь салбарынх нь ерөнхий эрсдэлээс дээгүүр эсвэл доогуур байгааг тодорхойлоход нь тусална. МЭҮЭ-үүд 8 дугаар бүлэгт тодорхойлсон салбарынхаа эрсдэлийг авч үзэх үед эдгээр эрсдэлийн гол хүчин зүйлсийг анхааралдаа авч үзэх хэрэгтэй.

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Өндөр орлоготой харилцагчид үйлчлүүлдэг • Гадаадын иргэд болон хуулийн этгээд, дотоодын иргэд голлодог • Харилцагчдыг таньж мэдэхэд төвөгтэй • Олон тооны харилцагчид үйлчлүүлдэг • Олон тооны мэргэжлийн харилцагчид үйлчлүүлдэг • Гишүүнчлэл шаарддаггүй эсвэл харилцагчдын суурь тогтмол бус	• Орлого багатай харилцагчид үйлчлүүлдэг • Дотоодын хуулийн этгээд үйлчлүүлдэг • Харилцагчдыг шууд таньж мэдэх боломжтой • Цөөн тооны тодорхой харилцагчид үйлчлүүлдэг • Энгийн харилцагчид үйлчлүүлдэг • Гишүүнчлэлийн хатуу бодлоготой эсвэл харилцагчдын суурь тогтмол, тодорхой
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Гүйлгээ нь өндөр дүнтэй, хэлбэлзэл ихтэй • Өндөр төлбөртэй хэдий ч эргэн хүлээн авах үр ашиг сайтай • Хөрвөх чадвар сайтай, уян хатан нөхцөлтэй • Шат дамжлага олонтой, олон тооны оролцогчоор дамжин хийгддэг – нарийн төвөгтэй • Гүйлгээ нь бэлэн мөнгөөр хийгддэг • Богино хугацаатай • Хэлцэл гүйлгээний дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодог	• Бага дүнтэй, тогтмол эсвэл тогтоосон гүйлгээ хийгдэг • Үнэ багатай, эргэн төлөлт, нөхөн олговор хийгддэггүй • Хөрвөх чадвар бага, хатуу нөхцөлтэй • Шууд нэг оролцогчоор дамжин хийгддэг • Урт хугацаатай • Хэлцэл гүйлгээний дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодоггүй
Хүргэх арга, хэлбэр	• Харилцагч нэрээ нууцлах боломжтой (anonymity) • Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нүүр тулан гүйцэтгэдэггүй • Харилцагчтай шууд харилцдаггүй • Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлдэг	• Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нүүр тулан тогтмол гүйцэтгэдэг • Харилцагчтай шууд харилцдаг • МЭҮЭ харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг өөрөө гүйцэтгэдэг

	• Гүйлгээг зайнаас гүйцэтгэх боломжтой	
Газар зүйн байршил	• Хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагаас өөр улс, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг • Салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг • Эдийн засгийн чөлөөт болон хилийн бүс эсвэл хяналтын тогтолцоо сул, суурь гэмт хэрэг гарах эрсдэл өндөртэй байршилд үйл ажиллагаа явуулдаг	• Хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагатай нэг улс, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг • Салбар, төлөөлөгчийн газар байхгүй
Бүтэц, зохион байгуулалт	• МэҮЭ-ийн өөрийн эцсийн өмчлөгчид нь УТНБЭ болон бусад эрсдэлтэй өмчлөгчдөөс бүрддэг • Эцсийн өмчлөгчдийн тоо, шаардлагад хязгаар тавьдаггүй, эцсийн өмчлөгчдийг олж тогтооход төвөгтэй • Дүрмийн сангийн шаардлага, хэмжээ өндөр • МУТС төрөлхийн эрсдэл өндөртэй үйл ажиллагааг эрхэлдэг • Өрсөлдөөн ихтэй, маркетингийн үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлдэг • Эрсдэл бүхий компаниуд бүхий санхүүгийн нэгдэлд багтдаг • Олон ажилтантай байгууллагад МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болно • Жижиг байгууллага дахь МУТС эрсдэлийн талаарх ойлголт сул байж болно • Хүний нөөц дутагдалтай, хүний нөөцийн хөдөлгөөн ихтэй.	• МэҮЭ-ийн эцсийн өмчлөгчдөд УТНБЭ болон бусад эрсдэлтэй этгээд байхгүй • Эцсийн өмчлөгчдөд шаардлага, хязгаар тавьдаг, эцсийн өмчлөгчдийг олж тогтооход хялбар • Дүрмийн сангийн шаардлага, хэмжээ бага • Өрсөлдөөн багатай, маркетингийн үйл ажиллагааг хууль тогтоомжоор хязгаарладаг • Санхүүгийн нэгдэлд багтдаггүй
Зохицуулалт	• Салбар, тухайн үйл ажиллагааг зохицуулах зохицуулалт сул эсвэл байхгүй • Төлбөр тооцоо, бүртгэлийг хянах үүрэг бүхий байгууллага байхгүй эсвэл үйл ажиллагаа нь доголдолтой	• Салбар, тухайн үйл ажиллагааг зохицуулах зохицуулалт хангалттай • Төлбөр тооцоо, бүртгэлийг хянах үүрэг бүхий байгууллага нь үр дүнтэй ажилладаг
Комплеанс	• МэҮЭ-үүдийн ойлголт, мэдлэг, хандлага хангалтгүй • МэҮЭ-үүдийн дотоод хяналтын тогтолцоо сул эсвэл байхгүй • МэҮЭ-үүдэд хяналт шалгалт хийгдэж байгаагүй эсвэл үр дүнтэй хийгддэггүй	• МУТС эрсдэлийн талаарх МэҮЭ-үүдийн ойлголт, мэдлэг, хандлага хангалттай • МэҮЭ-үүдийн дотоод хяналтын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлдэг

	• Тайлан мэдээлэл ирүүлэхгүй байх, хоцроох, тайлан мэдээллийг будилуулах (cooking the books) буруу гаргаж өгөх зэрэг үйлдэл тогтмол гардаг • Татвараас зайлсхийх, зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцож байсан түүхтэй	• МэҮЭ-үүдэд хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, арга хэмжээ авч ажилладаг • Тайлан мэдээллийг тогтмол ирүүлдэг, зөрчил дутагдал гаргадаггүй • Татварын хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэг, зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцож байгаагүй

БҮЛЭГ 4. АНХААРАХ ЗҮЙЛС

Анхаарах зүйлс (red flags) гэдэг нь харилцагчийн сэжигтэй үйл ажиллагааг илтгэх бөгөөд энэ тохиолдлыг МэҮЭ анхааралдаа авч тусгай хяналт тавих хэрэгтэй. Дараах анхаарах зүйлс төрөл бүрийн эх үүсвэрээс үүсэж, хяналт тавих шаардлага үүсэж болно.

Харилцагчтай харилцаа үүсгэхийн өмнө	• Харилцагч сандарсан байдалтай, өөрийн бичиг баримтаа өгөхөөс татгалзах • Харилцагчийн оршин суугаа хаяг болон санхүүгийн байгууллагын хооронд хамаарал байхгүй • Харилцагчийн өгсөн мэдээлэл бусад эх үүсвэрээс авсан мэдээлэлтэй нийцэхгүй байх • Харилцагч өөрийн эдийн засгийн нөхцөл байдалтай нийцэхгүй үндэслэлгүй хөрөнгөжих • Туршлагагүй хөрөнгө оруулагч хэдий ч их хэмжээний хөрөнгө оруулалт хийж буй харилцагч • Харилцагч эцсийн өмчлөгчийг нуун дарагдуулах зорилго бүхий төвөгтэй траст эсвэл хуулийн бусад зохицуулалттай байх • Харилцагч нь улс төрд нөлөө бүхий этгээд • МУТСТ чиг үүрэг бүхий ОУБ-аас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсын оршин суугч
Харилцагчтай харилцах үед	• Харилцагчийн мэдэгдэж байгаа хөрөнгийн мэдээлэлтэй нийцэхгүй сэжигтэй, тайлбарлагдахгүй их дүнтэй мөнгө дансанд нь орсон • Гуравдагч этгээдээс тодорхой шалтгаангүйгээр илгээсэн чек гэх мэт сэжигтэй гүйлгээнүүд • Дансаар дамжуулан гүйлгээ хийгдэж байгаа харагдуулахын тулд ашиг багатай эсвэл алдагдалтай худалдан авах, худалдах захиалга хийх зэрэг эдийн засгийн илт үндэслэлгүй гүйлгээнүүд • Хөрөнгийн борлуулалт, шилжилт хөдөлгөөн богино хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтууд • Мэдэгдэж байгаа хөрөнгөнөөсөө давсан дүнгээр дансаа алдагдлыг нөхөөд эсвэл дансандаа мөнгө байршуулж байгаа харилцагч • Харилцагчийн хөрөнгө оруулалт нь түүний хөрөнгө оруулалтын хэв маягтай нийцэхгүй байх • Өмнө нь идэвхгүй байсан дансаар гэнэт тайлбарлагдаагүй гүйлгээ хийгдэх • Харилцагч болсноосоо төд удалгүй бусад өндөр орлоготой харилцагчдыг санал болгож буй шинэ үйлчлүүлэгч • Дансанд нь бэлэн мөнгө ороод, төд удалгүй худалдаа хийгдэлгүйгээр буцаан авах • Харилцагчийн нас нь хөрөнгө оруулалтын эсвэл худалдан авалтын зан төлөвтэй нийцэхгүй байх – тэд нэрээ ашиглуулж байх магадлалтай (хэтэрхий залуухан эсвэл настай харилцагч) • Харилцагчийн хөрөнгө нь тэдний мэдэгдэж буй нөхцөл байдалтай таарахгүй байх • Харилцагч их дүнтэй буюу тодорхой бүтэцтэй бэлэн мөнгийг хөрөнгө оруулахаар МэҮЭ-ийн банкны дансанд хийх

Харилцагчтай харилцааг дуусгах үед	• Нэг данс нь тогтмол хэрэглээнд бус зөвхөн ганц гүйлгээнд хэрэглэгдэх • Харилцагчийг таньж мэдэх нэмэлт мэдээлэл (хөрөнгийн эх үүсвэр гэх мэт) шаардсаны дараа харилцагч дансаа хаах • Харилцагч илт хамааралгүй гуравдагч этгээдэд эсвэл эсвэл гадаад дахь данс руу хөрөнгийг илгээхийг хүсэх

БҮЛЭГ 5. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТОХИОЛДЛУУД

5.1 Мөнгө угаах үе шатууд

Гэмт хэрэгтнүүд хууль бус мөнгө эсвэл хөрөнгөө дараах үе шатаар дамжуулан угаадаг. Үүнд:

- **Байршуулах:** Гэмт хэрэгтнүүд бохир мөнгөө санхүүгийн системд байршуулна.
- **Нуун далдлах:** Хууль бусаар олсон хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах, төөрөгдүүлэх зорилгоор олон тооны нарийн төвөгтэй гүйлгээг хийх замаар санхүүгийн системд эргэлдүүлнэ.
- **Буцаан төвлөрүүлэх:** Хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулахын тулд нэмэлт гүйлгээнүүдийг хийх замаар хөрөнгийг өөртөө эргэн татан төвлөрүүлнэ.

СЗХ-ны хяналт тавих үүрэгтэй 5 салбарыг мөнгө угаах дээрх гурван үе шатанд бүгдэд нь ялангуяа нуун далдлах, буцаан төвлөрүүлэх үе шатанд ашиглах боломжтой.

5.2 Суурь гэмт хэргүүд, тэдгээрийн нөхцөл байдал

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж "бохир" мөнгийг "цэвэр" буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлогыг мөнгө угаах гэдэг. "Бохир" мөнгийг бий болгосон гэмт үйлдэл, хэргийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг гэдэг. Мэдээлэх үүрэгтэй этгээдүүд мөнгө угаах суурь гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээлэлтэй байх хэрэгтэй.

Өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига; дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хэрэгт хар тамхи, контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой эрсдэл багтаж байна. Эдгээр суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлогын үндсэн хэсгийг Монгол Улсад, үлдсэн хэсгийг (ялангуяа авлигын) оффшор бүсэд угааж байна[1].

Дээр дурдсан өндөр болон дундаж эрсдэлтэй суурь гэмт хэргийн нөхцөл байдлыг бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл дээр үндэслэн авч үзлээ. Салбарын МэҮЭ-үүд, тэдгээрийн ажилтнууд суурь гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлс зэргийн талаар мэдээлэл, ойлголттой байж эрсдэлд суурилсан МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, түүн дотроо харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа харгалзан үзэх шаардлагатай.

Залилах гэмт хэрэг: Өмчлөх эрхийн гэмт хэргүүдээс хулгайлах гэмт хэргийн дараа залилан мэхлэх гэмт хэрэг хамгийн их үйлдэгдэж байна. Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-

[1] "Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний тайлан", Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ) 2017 оны 9 дүгээр сар.

ын мэдээллээр 2018 онд улсын хэмжээнд залилах гэмт хэргийн 5,372 тохиолдол бүртгэгдсэн нь 2017 оныхоос 79.3%-өөр нэмэгджээ.[2] Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2017 онд нийт 9,275 иргэн, 4 хуулийн этгээд хохирч, гэмт хэргийн улмаас учирсан 123.2 тэрбум төгрөгийн хохирлын 48.4 тэрбум төгрөг буюу 39.3 хувийг нөхөн төлүүлж, 26.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. Бүртгэгдсэн залилах гэмт хэргийн дундаж хохирлын хэмжээ 41.1 сая төгрөг байжээ.[3] Залилах гэмт хэрэг нь дараах шалтгаан нөхцөл, хүчин зүйлийн улмаас үйлдэгдэж байна. Үүнд:

(i) Залилах гэмт хэрэг гол төлөв санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас үйлдэгдэж байна. тухайлбал, амьдралын хэрэгцээний зүйл болсон гар утас, машин, орон сууц зэргийг олж авахын тулд худал ярьж түр хэрэглэхээр авч буцаан өгөхгүй байх, худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ зэрэг иргэний эрх зүйн гэрээ байгуулж итгэл эвдэх замаар залилан мэхэлж бусдад хохирол учруулсан тохиолдол их үүссэн байна. Ялангуяа зээлийн гэрээ байгуулж зээлээ эргэн төлөхгүйгээр сураггүй болох замаар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа бөгөөд зээлтэй холбоотой гэмт хэрэг цөөнгүй үүсэж байгаа шалтгаан нь банкны зээлээ эргэн төлж чадахгүй болсон, зээлийн өрнөөс чөлөөлөгдөхийн тулд түр зуур хувь хүнээс зээл авсан, банкны зээл авах шаардлага хангаагүйн улмаас зээл авах боломжгүй болсон, гэнэт мөнгө шаардлагатай болсон зэрэг санхүүгийн хүнд нөхцөлөөс шалтгаалсан байна.

(ii) Иргэдийн сонор сэрэмж сул байгааг ашиглан өөрийнхөө тухай бусдад худал ярьж эд хөрөнгө залилан мэхэлж авсан хэрэг цөөнгүй байна. Жишээлбэл, өөрийгөө захиргааны байгууллагын ажилтан гэж итгүүлж, хураамж хэлбэрээр (тухайлбал, тусгай зөвшөөрөл гаргаж өгнө, газрын эрх олгоно хэмээн худал ярьж) залилан мэхлэх хэрэг үйлдэж байна. Мөн шашин шүтлэгийг ашиглан өөрийгөө зурхайч, лам гэж худал ярьж, мөнгө эд зүйл авсан гэх мэтийн хэрэг үүссэн байна.

(iii) Нийгмийн чиг хандлага, нөхцөл байдал. Иргэд гадаад руу цагаачлах, хөдөлмөр эрхлэх, сонирхол нэмэгдсэний улмаас ашиглан гадаадад зорчих виз гаргаж өгнө гэж хуурч мэхэлснээр их хэмжээний хохирол учирч байна. Үүнээс гадна Монгол залуучуудын дунд гадаадын их дээд сургуульд суралцах сонирхол нэмэгдсэнийг ашиглан сургуульд зуучилна хэмээн хууран мэхэлж бусдын эд хөрөнгийг авах гэмт хэрэг бий болж байна.[4]

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг: Энэ төрлийн гэмт хэрэг 2017 онд улсын хэмжээнд 128 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 56 хэргээр буюу 77.8 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэрэг 2016 онд 165 бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.7 тэрбум төгрөг буюу 55.1 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нь хөдөө хээрт зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин худалдаалах, тээвэрлэх, хадгалах, ашиглах үйлдэл нь зөвхөн худалдагч худалдан авагч нарын дунд далд хэлбэртэй явагддаг зэргээр нуугдмал шинжтэй, нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг юм. Хууль бусаар буюу зохих зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнасан, мод бэлтгэсэн, ашигт малтмал олборлосон, химийн хорт бодис ашигласан зэрэг үйлдэл ихэнх хувийг эзэлж байна. Ялангуяа ашигт малтмал олборлох хэрэгт төрийн албан хаагчид аж ахуйн нэгж, компанийн эзэдтэй хуйвалдах, тусгай

[2] "Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ", Цагдаагийн ерөнхий газар.

[3] "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017", Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2018 он.

[4] "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016", Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

хамгаалалттай газар хууль бус үйл ажиллагаа явуулсан хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна. Жишээ нь:

Типологи жишээ #1 (Суурь гэмт хэрэг): Төв аймгийн Заамар суманд "Сүлд майнинг Ресурс" ХХК-ийн захирал, сумын Засаг даргатай хамтран хууль бусаар ашигт малтмал олборлосон, "Мон дулаан трейд" ХХК нь MY000211 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн хууль бус 4.5 га газарт олборлолт явуулж, 614.9 сая төгрөгийн хохирол учруулсан.

Баянхонгор аймгийн Өлзийт суманд иргэн Г, Б нар нь нөхөн сэргээлт явуулах нэрийдлээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан.

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Наран багийн нутагт иргэн Г нь 9.8 кг цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёог түүж бэлтгэсэн.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн шалтгаан нь иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, амьтан ургамлын эд эрхтнийг хэрэглэвэл бие эрүүл болно гэсэн сэтгэлгээнээс үүдэлтэй байна.
Энэ төрлийн гэмт хэргийн 15 орчим хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг эзэлж байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй 2000 гаруй ААНБ, хувиараа алт олборлож байгаа 90.0 мянга орчим иргэнтэй харьцуулахад энэ гэмт хэргийн нуугдмал хэв шинж байх магадлал өндөр байна. "Нинжа" нар төрөл хэлбэрийн хувьд өргөжиж, алт, гянтболд, өнгөт чулуу, нүүрс самар зэргээр хүрээгээ тэлжээ.[5]

Татвараас зайлсхийх гэмт хэрэг: Олон улсад хийсэн криминологийн судалгаагаар бүртгэгдсэн 1 гэмт хэргийн ард 3-10 гэмт хэрэг нуугдаж байдаг бол авлига, татвараас зайлсхийх зэрэг онцлог гэмт хэргүүдийн цаана 1:100 гэмт хэрэг нуугдаж байх бүрэн магадлалтай ажээ. Монгол Улсад жилд татвараас зайлсхийсэн 60-90 татварын маргаанд эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг гэж үзвэл дор хаяж 600-900 татвараас зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэгдсэн байх магадлалтай. Нуугдмал гэмт хэргийн улмаас улсын төсөвт төвлөрөх ёстой хэчнээн хэмжээний орлого алдагдсаныг 2015 онд баталсан Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиар ил болсон 36 их наяд төгрөгийн орлогоос харж болно. Татвараас зайлсхийх гэмт хэрэг дараах хэлбэрээр үйлдэгдэж байна.

1. Татвар ногдох эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх газар зэргийг зах зээлийн үнээс бага үнээр борлуулсан эсвэл өндөр үнээр худалдан авснаар гэрээ хэлцэл хийх;
2. Бусад татвар төлөгчтэй үгсэн хуйвалдаж, санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт материалыг хуурамчаар үйлдэн, татвар ногдох зүйлийг нуух, санаатайгаар багасгах, өртөг зардлаа зохиомлоор өсгөж санхүүгийн тайлан тэнцэл, татварын ногдуулалт, төлөлтийн тайланг үндэслэлгүй буруу гаргах;
3. Улсын бүртгэлд бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа эрхлэх, НӨАТ төлөгчөөр зориуд бүртгүүлэхгүй байх;

[5] "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016", Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

4. Импортолсон барааны үнийг гаалийн байгууллагад багаар, НӨАТ-ын бүцаан авалтын үед өндрөөр мэдүүлэх;
5. Бусад хүний нэрээр бараа материал импортлон борлуулж татварын ногдуулалт, төлөлтийн тайланг гаргахгүй байх;
6. Улсын бүртгэлд бүртгүүлсэн хаяг, байршилдаа байхгүй, олдохгүй байх, татварын албанаас дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байх;
7. Үнэ шилжүүлэх, нимгэн капиталжуулалт зэрэг аргыг ашиглан татвараас зайлсхийх зэрэг болно.[6]

Авлигын гэмт хэрэг: Авлигатай тэмцэх газар 2017 онд гэмт хэргийн шинжтэй 658 гомдол, мэдээллийг хүлээн авсан бөгөөд төрлөөр нь авч үзвэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан 337, хахууль авсан 63, хахууль өгсөн 76, албан тушаалтан өмч хөрөнгө завшсан 82, хөрөнгө нуусан буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн 51, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 48, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан 50, бусад 6 хэрэг байжээ.

Гомдол мэдээлэлд холбогдон шалгагдсан 709 албан тушаалтнаас төрийн улс төрийн 137, төрийн захиргааны 115, төрийн тусгай 220, төрийн үйлчилгээний удирдах 105, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 47, төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдах 41, бусад 44 албан тушаалтан холбогдон шалгагдсан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 174 буюу 26.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх (эрүүгийн хэрэг үүсгэх), 375 буюу 58 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзах (эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах), 93 буюу 14.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай харьяа прокурорт шилжүүлэн шийдвэрлэжээ.

Хуульд заасан харьяаллын 1301 үйлдэлтэй, 654 холбогдогчтой, 427 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргээс 106-г буюу нийт шалгасан хэргийн 24.8 [7]хувийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар, 94-ийг буюу 22.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтайгаар тус тус прокурорт, 48-ыг буюу 11.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 14 буюу 3.2 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, 2 хэргийг түдгэлзүүлж, оны эцэст 163 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулж байжээ.

[6] “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

[7] Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2018 он.

БҮЛЭГ 6. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Монгол Улсын Их хурлаас 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийг батлан гаргасан.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.1-д ""терроризм" гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг" ойлгоно гэж заасан бол 3.1.3.ё-д зааснаар "терроризмыг санхүүжүүлэх, шууд болон шууд бусаар аливаа туслалцаа, дэмжлэг үзүүлэх"-ийг "террорист үйл ажиллагаа" гэж ойлгоно гэжээ.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 3.1.2-д ""терроризмыг санхүүжүүлэх" гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг", 3.1.11-д ""үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх" гэж Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20–д заасныг" тус тус ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20-д ""үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх" гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах ашиглахад бүрэн үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг" ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 3.1.2-д заасан "терроризмыг санхүүжүүлэх", Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20-д заасан "үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх" гэсэн нэр томъёог хамтад нь "терроризмыг санхүүжүүлэх" гэж тодорхойлон, энэхүү тайланд ашигласан болно.

Террорист үйл ажиллагааг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд террористуудад хөрөнгө мөнгө шаардлагатай болдог. Үүнд алан хядагч террористуудын байрны түрээс, хоолны төлбөр гэх зэрэг энгийн зүйлс ч байж болно. Терроризмыг санхүүжүүлэх (ТС) үйл ажиллагааны шинж чанар нь мөнгө угаах (МУ) үйл ажиллагаатай олон талаараа төстэй байдаг. Гэсэн хэдий ч ТС нь эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаасаа өвөрмөцц онцлогтой.

Шинж чанарын хувьд ТС үйлдлийг олж тогтооход илүү төвөгтэй. Хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны болон хууль бус байж болох бөгөөд ихэвчлэн бага дүнтэй гүйлгээнүүд байдаг. Тиймээс ТС үйл ажиллагааны хувьд эх үүсвэр, санхүүжүүлж буй үйл ажиллагааны мөн чанарыг нууцлахад чиглэгддэг.

АНДББ-аас 2017 хийсэн Харилцан үнэлгээний тайланд "Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж магадгүй. Мэдээллийн нээлттэй эх сурвалжаас харахад Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа

Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна. Монгол Улсад террорист халдлага гарсан эсхүл террорист бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан гэх тохиолдол бүртгэгдээгүй аж" гэж дүгнэсэн байдаг.

Монгол Улсын Тагнуулын ерөнхий газраас "Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ"[8]-г гаргасан. Терроризмыг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээ гэдэг нь террорист байгууллага, бүлэглэл, этгээдийн болон террор үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар зарцуулагдах хуримтлуулсан, шилжүүлсэн эд хөрөнгө, эргэлт, түүнд тавьж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хяналт, шалгалт, тэдгээрийн аюул занал, эмзэг сул байдлын үнэлгээний нийлбэрт хийсэн дүн шинжилгээний **"таамаг"** юм.[9]

Үнэлгээний ажлын хэсгээс хийсэн судалгаа, гишүүн байгууллагуудаас ирүүлсэн мэдээ мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийхэд Монгол Улсын Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдлийн ерөнхий үнэлгээний түвшин **Шар** буюу **"дундаас дээш эрсдэлтэй түвшин"** (*Монгол Улсад террорист гэмт хэрэг, халдлага үйлдэгдэх эрсдэл бага түвшинд боловч манай улсад терроризмын суурь нөхцөл үүсч болзошгүй нөхцөл байдлууд нь дунд түвшинд байгаа нь эрсдлийг "дундаас дээш" түвшин рүү нэмэгдүүлж байна*)-д гарсан тул Монгол Улсын хэмжээнд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрсдэлийн үнэлгээ хийсэн салбар	Терроризмыг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээ	ҮОХЗ дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээ
Банкнаас бусад санхүүгийн байгууллага	**57.5%**	**62.5%**
Үл хөдлөх хөрөнгө зуучлал	**60.0%**	**62.5%**
Арилжааны банк	41.25%	50.0%
Хуулийн этгээд - Ашгийн байгууллага	47.5%	50.0%
Хуулийн этгээд - Төрийн бус байгууллага	62.5%	65.0%
Хилийн хяналт	48.75%	60.0%

Энд: 0-20% эрсдэлгүй, 21-40% бага эрсдэлтэй, 41-60% дунд эрсдэлтэй, 61-80% өндөр эрсдэлтэй, 81-100% бодит эрсдэлтэй.

Одоогийн байдлаар банкнаас бусад санхүүгийн салбарт терроризмыг санхүүжүүлсэн гэмт хэргийн тохиолдол бүртгэгдээгүй. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд гадаад валютын арилжаа, гадаад мөнгөн шилжүүлэг зэрэг үйлчилгээнээс бусад үйлчилгээний хувьд терроризмыг санхүүжүүлэх эрсдэл харьцангуй бага гэж СЗХ үзэж байна. Учир нь салбарын хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчин харьцангуй сайжирч хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор

[8] Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар: https://gia.gov.mn/5/item/548
[9] Аргачлалыг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг https://gia.gov.mn/5/item/548 линкээр орж үзнэ үү.

холбогдох дүрэм, журамд терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зүйл, заалтуудыг тусгайлан тусгахаар ажиллаж байна.

Хэдийгээр банкнаас бусад санхүүгийн байгууллагын салбарт СЗХ-ны зүгээс холбогдох сургалт, мэдээлэл түгээх үйл ажиллагаа тогтмол явуулдаг ч зохицуулалттай салбарын хувьд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар ойлголт, мэдлэг, мэдээлэл салбарын хэмжээнд төдийлэн хангалтгүй байгаагаас шалтгаалж эрсдлийг төдий чинээгээр нэмэгдүүлж байна.

Тус салбарын хүрээнд терроризмыг шууд санхүүжүүлэх гэхээс илүүтэй терроризмыг санхүүжүүлэх зорилгоор орлого хураан цуглуулах, хуримтлуулах эрсдэл байж болох талтай. Ялангуяа банкнаас бусад санхүүгийн салбар ихэнх тохиолдолд дотоод руу чиглэсэн үйлчилгээ, гүйлгээ явуулж байгаа нь энэ салбарт дээрх эрсдэл нэмэгдэх нэг хүчин зүйл гэж үзэж болохоор байна.[10]

Гэсэн хэдий ч МэҮЭ-үүд даяаршлын өнөөгийн нөхцөл байдалд сонор сэрэмжтэй байж, байнгын анхааралтай хандах шаардлагатай.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 6[1].1-д "Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17, 3.1.18-д заасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно" гэж заасан байдаг. МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 6[1] дүгээр бүлэгт заасны дагуу МэҮЭ дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Харилцагч, түүний гүйлгээг хүлээн авагч этгээд хориг арга хэмжээний жагсаалтад орсон орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэл мөн эсэхийг таньж мэдэх;
2. Хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай тагнуулын байгууллага, Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлэх;
3. МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, шаардлагатай бол хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17-д ""хориг арга хэмжээний жагсаалт" гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг", 3.1.18- д ""дотоодын жагсаалт" гэж үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотойгоор терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг" тус тус ойлгоно гэж заасан байдаг.

[10] https://gia.gov.mn/5/item/548

Иймд МэҮЭ-үүд нь дээр дурдсан хориг арга хэмжээний жагсаалт болон дотоодын жагсаалтыг үйл ажиллагаандаа ашиглаж, харилцагчийг таньж мэдэж, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гол үзүүлэлт болон анхаарах зүйлс

ТС-тэй холбоотой байж болзошгүйг илтгэх зарим анхаарах зүйлсийг оруулаа. Энэ нь бүх боломжит хувилбар биш бөгөөд МэҮЭ өөрсдийн бизнесийн үйл ажиллагааны онцлогт тохируулан гарч болох бусад хүчин зүйлсийг ч уг жагсаалтад оруулах шаардлагатай.

- Өндөр эрсдэлтэй бүс нутагт байрлах хүлээн авагчид руу харилцагч олон тооны хөрөнгийн шилжүүлэг хийх;
- Хувь хүн болон ААНБ-ууд террорист байгууллага эсвэл терроризм, ТС-тэй холбоотой гэж тодорхойлогдсон болон тэдгээртэй холбоотой байж болзошгүй гэж сэжиглэгдэж байгаа байгууллагууд руу хөрөнгө шилжүүлэх;
- Олон харилцагч нэг ижил хаяг, утасны дугаарыг ашиглан дансны гүйлгээ хийх (үйл ажиллагаа явуулах);
- Хуурамч бичиг баримтаар данс нээлгэх;
- Мөргөлдөөнтэй байгаа бүс нутгаас эргэж ирсэн эсвэл тэнд байгаа харилцагчид;
- Харилцагчийн төлөв байдалтай нийцтэй бус байдлаар түүний дансны үйл ажиллагаа гэнэт идэвхжих;
- Нэг данс руу бага дүнтэй олон тоотой хийгдсэн дотоодын шилжүүлэг гэх мэт.

ТС эрсдэл хурдан өөрчлөгдөж байгаа учраас ТС эрсдэлийн үнэлгээг хийхдээ илүү алсыг харсан байдлаар, шинээр үүсч буй нөхцөл байдлыг соргогоор харж хамруулж авч үзэхийг салбарын МэҮЭ-үүдэд зөвлөж байна. МэҮЭ-үүд нь өөрсдийн МУТСТ арга хэмжээ, журамдаа эдгээр шинээр үүсэж буй ТС нөхцөл байдлыг зохих хэмжээнд үр дүнтэй хамруулж, байнга хяналт тавьж, туршиж байх хэрэгтэй.

МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд МэҮЭ-үүд нь дараах хоёр бүлэг хориг арга хэмжээний шинэчлэгдсэн жагсаалтыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа байнга ашиглах шаардлагатай. Үүнд:

1. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалт (United Nations Security Council Consolidated List)[11];
2. ФАТФ-аас гаргасан хориг арга хэмжээ авах улс орнуудын "хар жагсаалт" болон МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой улс орнуудын "саарал жагсаалт".

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалт: МэҮЭ-үүд НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн хориг арга хэмжээний мэдээлэл бүхий дээрх линкээр орж хамгийн сүүлийн үеийн шинэчлэгдсэн хориг хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн мэдээллийг (pdf, xml, html хэлбэрээр) татан авч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай.

[11] https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list

Уг жагсаалтад хувь хүн болон хуулийн этгээд, бүлэглэл гэсэн 2 жагсаалтаас бүрдэх бөгөөд латин цагаан толгойн үсгийн дарааллаар эрэмбэлсэн байдаг. Жагсаалтад тухайн этгээдийг таньж мэдэхтэй холбоотой боломжит мэдээллийг тухайлбал, хувь хүний хувьд дөрвөн төрлийн нэр, эх хэл дээр нь хэрхэн бичигдсэн байдаг, төрсөн газар, төрсөн огноо гэх мэт мэдээллийг багтаасан байдаг.

ФАТФ-аас гаргасан жагсаалт: ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах улс орныг өндөр эрсдэлтэй (high-risk) "хар жагсаалт" дахь улс орноор тодорхойлсон байгаа бөгөөд эдгээр улсын эсрэг хориг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж тодорхойлсон байна. Үүнд:

1. Иран (Iran)[12];
2. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (Democratic People's Republic of Korea)[13]

Түүнчлэн дараах улс орныг ФАТФ-аас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой (other monitored jurisdictions) гэж тодорхойлж "саарал жагсаалт"-д оруулсан байна. Үүнд:

1. Бахамын арлууд (Bahamas);
2. Ботсвана (Botswana);
3. Камбож (Cambodia);
4. Гана (Ghana);
5. Исланд (Iceland);
6. Монгол (Mongolia);
7. Пакистан (Pakistan);
8. Панам (Panama);
9. Сири (Syria);
10. Тринадад ба Тобаго (Trinadad and Tobago);
11. Йемен (Yemen);
12. Зимбабве (Zimbabwe)[14].

Салбарын МэҮЭ-үүд ФАТФ-ын вэб хуудсанд тогтмол зочилж, "хар жагсаалт" болон "саарал жагсаалт"-д орсон улс орнуудын мэдээллийг авч, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа тогтмол ашиглах шаардлагатай.

Монгол Улсад терроризмыг санхүүжүүлэх болон ҮОХЗ дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэрэг одоогоор бүртгэгдээгүй байгаа учраас мэдээлэл өгөх зорилгоор Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ - APG)-аас 2019 оны 8 дугаар сард гаргасан "2019 оны жилийн типологи судалгааны тайлан"-гаас зарим кэйсийг орууллаа.

[12] https://www.fatf-gafi.org/countries/#Iran
[13] https://www.fatf-gafi.org/countries/#Democratic%20People's%20Republic%20of%20Korea%20(DPRK)
[14] https://www.fatf-gafi.org/countries/#other-monitored-jurisdictions

Типологи жишээ #2 (Терроризмыг санхүүжүүлэх - Малайз улс):
Сири дэх Малайзын террористуудын нууц мессежийн аппликэшнээр дамжуулсан зааварчилгааны дагуу дэмжигчид нь 2016 оноос хойш 7,000 гаруй ам.долларыг цуглуулсныг мөрдөн байцаагчид олж илрүүлжээ. Цуглуулсан хөрөнгийн ихэнх хэсгийг Сири болон Ирактай ойролцоо улсын болон бусад дамжуулагч улсын мөнгөн гуйвуулгын компаниудын сүлжээг ашиглан Малайзын санхүүгийн байгууллагуудаас шилжүүлсэн байжээ.
Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид үйлдлээ нуухын тулд хөрөнгийг гадаадад шилжүүлэхийн өмнө өөр хоорондоо хэд хэдэн удаа шилжүүлжээ. Уг хөрөнгийг бараа, тэсрэх бодис тээвэрлэх ачааны машин худалдан авах, Сирид террористуудын зорчих, амьдрах зардлыг санхүүжүүлэхэд ашигласан гэж үзэж байна.

Эрх бүхий байгууллагын жагсаалтад өмнө нь орсон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хоорондын нэг удаагийн гүйлгээ мэдээлэх үүрэгтэй этгээдийн гүйлгээний хяналтын системээр илэрчээ. Нийт 8 санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийг Малайзын Эрүүгийн хуулийн 130N(b), 130O(1), 130Q(1)-д заасны дагуу 4-10 жилийн хорих ялаар шийтгэжээ. Банкны гүйлгээ/гадаад дахь банкны данс ашиглах, банкнаас гадуурх шилжүүлгийн үйлчилгээ/Хавала зэрэг терроризмыг санхүүжүүлэх аргыг энд ашиглажээ.

Типологи жишээ #3 (Терроризмыг санхүүжүүлэх - Филиппин улс):

Maute Group (MG) нь Өмнөд Филиппин дэх Daesh / Ирак, Сирийн Исламын улс (Islamic State of Iraq and Syria (ISIS))-ыг дэмжигч бүлэглэл бөгөөд Өмнөд Филиппиндээ нэр нөлөө бүхий гэр бүлүүдийн овог.
Террористуудын санхүүжилтийг босгодог CJ (гадаадын террорист байгууллага)-ийн сүлжээний гишүүд 2017 оны 1 дүгээр сараас 2 дугаар сарын хороонд олон улсын мөнгөн гуйвуулгыг Филиппин рүү илгээж байжээ. Эдгээр гүйлгээг бүгдийг нь олон улсын мөнгөн гуйвуулгын платформ ашиглан зөвхөн нэг гуйвуулгын агентлаг, сүлжээгээр хүлээн авсан байжээ. Уг мөнгийг хүлээн авагч нар Филиппин дэх албан ёсны бизнесийн байгууллага руу оруулж байсан хэдий ч тэдний бизнестэй холбоогүй гүйлгээнүүд байжээ. Гадаадын зэвсэгт дайчид Филиппин улсад ирж санхүүжилтийг авах, бусад улс орон руу мөнгөн гуйвуулгаар шилжүүлэх замаар терроризмыг санхүүжүүлж байжээ.

БҮЛЭГ 7. ЭНЭХҮҮ ТАЙЛАН ДАХЬ ТОО МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ТАЙЛБАРЛАХ ВЭ

Төрөлхийн эрсдэлийн хүснэгт

Тухайн нэг МэҮЭ-ийн МУТС эрсдэл нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнээс шалтгаалан салбарын дундаж, салбарын түвшинд тодорхойлсон төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлсээс ялгаатай байж болно.

МэҮЭ-үүд салбарын эрсдэлийн үнэлгээг өөрсдийн үйл ажиллагааны онцлог, хамрах үрээнд нийцүүлэн уян хатан байдлаар ашиглах боломжийг олгохын тулд тухайн нэг МэҮЭ-ийн хувьд МУТС эрсдэлийг бууруулах болон нэмэгдүүлэх хэд хэдэн хүчин зүйлсийг энэхүү үнэлгээний тайланд тодорхойлж өгсөн. Энэхүү тайлан нь тухайн МэҮЭ-ийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарт нь МУТС эрсдэлийг бууруулах болон нэмэгдүүлэх боломжит хүчин зүйлс юу болох талаарх ойлголт, мэдээллийг өгөх зорилготой юм. МэҮЭ нь тухайн байгууллагын эрхэлж буй бизнес нь нийт салбарын эрсдэлээс юугаараа ялгаатай болохыг ойлгож, өөрсдийн онцлог эрсдэлийг тодорхойлох нь чухал юм.

Тоо мэдээллийн хамрах хугацаа

СЗХ-ны зохицуулалттай МэҮЭ-үүдийн хувьд сар, улирал тутам батлагдсан маягтын дагуу санхүүгийн болон бусад тайлан мэдээллийг ирүүлдэг. МэҮЭ-үүдийн 2018 оны жилийн эцсийн байдлаар СЗХ-нд ирүүлсэн тайлан мэдээлэл болон 2019 оны эхний хагас жилийн байдлаарх тусгай зөвшөөрлийн бүртгэл мэдээллийн сангийн мэдээлэл дээр үндэслэн энэхүү тайланд оруулсан үзүүлэлт мэдээллийг тодорхойлсон.

Тайлангийн 5.2 дугаар бүлэг авч үзсэн суурь гэмт хэргийн нөхцөл байдлын тоо мэдээллийн хувьд Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2017, 2018 онд гаргасан "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016" болон "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017" тайланд орсон тоо мэдээлэл, дүгнэлт, типологи жишээг авч ашигласан болно.

Түүнчлэн СЗХ-ноос 2018 онд хийсэн зохицуулалттай салбарын МэҮЭ-үүдийн "Мөнгө угаах эрсдэлийн үнэлгээний тайлан"-г мөн авч үзсэн.

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын хувьд холбогдох бүртгэлийн байгууллагын байгууллагууд тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон Эд хөрөнгийн бүртгэлийн газрын мэдээлэл болон салбарын мэргэжлийн холбоо, салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон байгууллагуудын мэдээлэл зэргийг ашигласан. Түүнчлэн СЗХ-ны захиалгаар Монголын Эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв ТББ болон МИРИМ Консалтинг ХХК-аас 2018 онд гүйцэтгэсэн "Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх судалгаа"-ны тайланг мөн ашигласан.

СЗХ-ны зохицуулалттай этгээдүүдийн хувьд зохицуулалтын хэд хэдэн салбарт, мөн салбар дотроо зохицуулалттай хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн нэг МэҮЭ-ийн мэдээлэл хамаарах салбар, үйл ажиллагааны хэсэг бүрд давхардаж орсон гэдгийг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн салбар, үйл ажиллагааны мэдээлэл,

тоон үзүүлэлт нь зөвхөн СЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалттай этгээдүүдийн мэдээллээр хязгаарлагдаж байгаа гэдгийг анхаарна уу.

БҮЛЭГ 8. САЛБАР БҮРИЙН МУТС ЭРСДЭЛ

Банк бус санхүүгийн байгууллага	**1,601.7 мянга** харилцагч * Давхардсан тоогоор	**1.3 их наяд** төгрөг * Нийт хөрөнгийн хэмжээ	**539** МэҮЭ-ийн тоо * Банк бус байгууллагын тоо
Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч	**717,751** харилцагч * Даатгуулагчдын тоо	**178.7 тэрбум** төгрөг * Нийт даатгалын хураамж	**94** МэҮЭ-ийн тоо * Ердийн даатгагч 15 Урт хугацааны даатгагч 1 Давхар даатгагч 2 Даатгалын зуучлагч 49 Даатгалын хохирол үнэлэгч 27
ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллага	**1,304,371** харилцагч * Үнэт цаасны данс эзэмшигчдийн тоо	**245.5 тэрбум** төгрөг * Нийт ҮЦ-ны арилжааны дүн	**193** МэҮЭ-ийн тоо * Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж буй ҮЦК 54; Үнэт цаасны итгэмжлэн удирдах компани 1 (хөрөнгө итгэмжлэн удирдах компани 3); Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, төвлөрсөн хадгаламжийн компани 1; Үнэт цаасны төлбөр, тооцооны компани 1; Кастодиан банк 3; Үнэт цаасны арилжаа эрхэлж буй компани 2; Хөрөнгө оруулалтын сан (ХОС) 15; Хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) 21; ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн, хөрөнгийн үнэлгээний, аудитын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага 95

Хадгаламж зээлийн хоршоо	**62,556** харилцагч * Гишүүдийн тоо	**200.2 тэрбум** төгрөг * Нийт хөрөнгийн хэмжээ	**279** МэҮЭ-ийн тоо * СЗХ-ноос зөвшөөрөлтэй хадгаламж, зээлийн хоршооны тоо
Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллага	∞ харилцагч * Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоог тодорхойлох боломжгүй	∞ төгрөг * Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллагаар зуучлуулсан борлуулалтын хэмжээг тодорхойлох боломжгүй	**3100 орчим** МэҮЭ-ийн тоо * ҮХЗ-ын үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн компанийн тоо. Үүнээс 130 гаруй компани идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, ҮЦЗЗ-д оролцогч мэргэжлийн байгууллага, ХЗХ-ны хувьд 2018 оны жилийн эцсийн болон 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх тоо мэдээллийг энд оруулав. Тухайлбал, "Санхүүгийн салбарын тойм – 2018 он" тайланд дурдагдсан тоо мэдээллийг ашиглав. Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллагын хувьд салбарын нэгдсэн бүртгэл, тоо мэдээлэл байхгүй бөгөөд 2018 онд СЗХ-ноос хийсэн "Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх судалгаа"-ны тайланд дурдагдсан тоо мэдээллийг ашиглав.

8.1 Банк бус санхүүгийн байгууллага

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны төрөлхийн эрсдэл

Бага | Дунджаас доош | Дунджаас дээш | Өндөр

ДД	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны тодорхойлолт	МУТС төрөлхийн эрсдэл
1	Зээл		Төрөлхийн эрсдэл өндөр. Хувь нийлүүлэгчдийн зүгээс дүрмийн санг бүрдүүлэх, харилцагчдын зүгээс хуурамчаар зээл авч эргэн төлөх эрсдэл үүсэх магадлалтай.
2	Факторингийн үйлчилгээ	зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагаа (4.1.2)	Төрөлхийн эрсдэл өндөр. Харилцагчдын зүгээс ББСБ-ыг ашиглан хуурамч гэрээ, хуурамч гүйлгээгээр мөнгө угаах эрсдэлтэй.
3	Төлбөрийн баталгаа гаргах	Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасан баталгааны гэрээгээр ББСБ нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч ББСБ-д төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ	Төрөлхийн эрсдэл өндөр. ББСБ-ыг ашиглан хуурамч гэрээ, хуурамч гүйлгээгээр мөнгө угаах эрсдэлтэй.
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах		Төрөлхийн эрсдэл өндөр. Гаргасан төлбөр тооцооны хэрэгслийг ашиглан бага дүнтэй хянагдах боломжгүй олон тооны гүйлгээг хийх замаар МУТС эрсдэлтэй.
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагаа (4.1.5)	Төрөлхийн эрсдэл өндөр. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан бага дүнтэй хянагдах боломжгүй олон тооны гүйлгээг хийх замаар МУТС эрсдэл үүсэх магадлалтай. Бүртгэл, гүйлгээг харилцагчтай нүүр тулахгүйгээр хийж байгаа нь харилцагчийг таньж мэдэх шатанд эрсдэлийг үүсгэнэ.

6	Гадаад валютын арилжаа	гадаад валютыг худалдах, худалдан авах, түүгээр зээл олгох, баталгаа гаргах үйл ажиллагаа (4.1.6)	Төрөлхийн эрсдэл өндөр. Гүйлгээний баримт үйлдэхгүй байх, харилцагчийг бүртгэхгүй байх зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлнэ.
7	Итгэлцлийн үйлчилгээ	итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаа (4.1.7)	Төрөлхийн эрсдэл өндөр. Харилцагч буюу итгэмжлэгчийг таньж мэдэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, итгэлцлийн гэрээ дуусгавар болох зэрэгт эрсдэл үүсэх магадлалтай.
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх (4.1.8)	Төрөлхийн эрсдэл өндөр. Харилцагч буюу хөрөнгө оруулагчийг таньж мэдэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, гэрээ дуусгавар болох зэрэгт эрсдэл үүсэх магадлалтай.
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх		Төрөлхийн эрсдэл бага. Харилцагчид үндэслэлгүй дүгнэлт, зөвлөмж өгөх үйлдэхүй, зөрчил дутагдлыг мэдсээр байж нуун дарагдуулах эс үйлдэхүйн эрсдэл үүсэх магадлалтай.

Банк бус санхүүгийн байгууллагын эрсдэлийн өнөөгийн ерөнхий түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	4.0	Олон тооны байгууллага ажилладаг (538 ББСБ). Гэсэн хэдий ч голчлон дотоодын харилцагчдад үйлчилдэг (2019 оны 2 дугаар улирлын байдлаар гадаадын оршин суугчдаас авсан хүүгийн орлого нийт хүүгийн орлогод 0.03%-ийг эзэлж байсан)
Бүтээгдэхүүн үйлчилгээ	4.0	Ихэнх үйл ажиллагаа нь төрөлхийн эрсдэл өндөртэй. Гэхдээ дотоодын харилцагчид - иргэд голчлон үйлчлүүлдэг.
Гүйлгээ	4.0	Гүйлгээний тоо эрчитэй нэмэгдэж байгаа хэдий ч гүйлгээний дүн бага
Харилцагч	3.0	Дотоодын иргэд голчлон үйлчлүүлдэг
Хүргэх суваг	3.0	Ихэвчлэн харилцагчидтай нүүр тулж харилцдаг, хэдий цахим үйлчилгээ нэвтэрч байгаа.
Дундаж оноо	**3.6**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	4.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дундаас дээш (санхүүгийн салбарт эзлэх байр суурь сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байгаа)
Нэр хүнд – итгэлцэлийн үр нөлөө	3.0	Нэр хүнд – итгэлцэлийн үр нөлөө дунд зэрэг (Зээл, гадаад валютын арилжаанаас бусад үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх шаардлагатай. ББСБ-д итгэх итгэл буурах нь эдгээр үйл ажиллагааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлнэ)
Дундаж оноо	**3.5**	

Эрсдэлийн түвшин	**12.6**

Банк бус санхүүгийн байгууллагын эрсдэлийн өнөөгийн түвшин, үйл ажиллагаа тус бүрээр

Энд: БХСХ – богино хугацаат санхүүгийн хэрэгсэл

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн зураглал



8.1.1. Зээлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Зээлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ: Өөрийн хөрөнгөөр харилцагчдад зээл олгох үйл ажиллагаа



Зээлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-ын хувьд харилцагчаас зээлийн хүсэлтийг хүлээн авч (1) судалгаа хийж, зээл олгох шийдвэр гаргах шатанд дараах чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд:

1. Харилцагчийг таньж мэдэх: улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл эсэхийг нягтлах.
2. Харилцагчийн төлөв байдлыг тодорхойлох: Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, тухайн хүн, хуулийн этгээдийн эрхэлж буй ажил, үйл ажиллагаатай холбоогүй эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй зээлийн хүсэлт гаргасан эсэх.
3. Эцсийн өмчлөгчийг тодорхойлох: бусдад зориулан өөрийн нэр дээр зээл авах хүсэлт гаргаж байгаа эсэхийг нягтлах, хамтран зээлдэгч, батлан даагчийг харилцагчийг таньж мэдэх дээрх шаардлагын дагуу таньж мэдэх.
4. Зээлийн барьцааны хөрөнгийн эх үүсвэрийг нягтлах: зээлийн барьцааны хөрөнгийн өмчлөл хэдэн удаа, хэрхэн өөрчлөгдсөнийг нягтлах.

Зээлийн эргэн төлөлт (4)-ийн шатанд зээлдэгчийн зүгээс эргэн төлөлтийг банкны дансаар дансаар дамжуулахгүйгээр бэлэн мөнгөөр хийх (улаан тасархай зураас), ББСБ-ын зүгээс зээл олголт, эргэн төлөлтийг банкаар дамжуулахгүйгээр бэлэн мөнгөөр хийх шаардлага тавих нь мөнгө угаах эрсдэлийг нэмэгдүүлэх болно.

Мөн зээлийн эргэн төлөлт (4), эргэн төлөлтийн явцад хяналт тавих (5) шатанд илүү төлөлт хийх, зээлийг хугацаанаас өмнө хаах зэрэгт тусгайлан хяналт тавих шаардлагатай.

ББСБ-аас зээл олгох үйл ажиллагаан дахь төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлс

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Ямар ч харилцагч зээл авах боломжтой – зээлийн болон барьцааны шаардлагыг хангаж байгаа тохиолдолд бүх харилцагч зээл авах боломжтой • Гадаадын иргэд болон хуулийн этгээд, дотоодын иргэд голлон үйлчлүүлдэг • Олон тооны харилцагчид үйлчлүүлдэг	• Зээлийн болон барьцааны шаардлагаас гадна харилцагчид шаардлага тавьдаг • Дотоодын хуулийн этгээд үйлчлүүлдэг • Харилцагчдыг шууд таньж мэдэх боломжтой • Цөөн тооны тодорхой харилцагчид үйлчлүүлдэг • Харилцагчдыг таньж мэдэх үйл ажиллагаанд олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашигладаг
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Өндөр дүнтэй зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог • Хугацаанаас өмнө илүү төлөлт хийхийг дэмждэг • Хугацаанаас өмнө зээл хаахад ямар нэг нэмэлт төлбөр, хураамж төлдөггүй • Гэрээний хугацаа богино, уян хатан нөхцөлтэй • Зээлийн дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодог	• Бага дүнтэй зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог • Хугацаанаас өмнө илүү төлөлт хийхийг дэмждэггүй • Хөрвөх чадвар бага, хатуу нөхцөлтэй, хугацаанаас өмнө зээл хаахад нэмэлт төлбөр, хураамж төлдөг • Зээлийн дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодоггүй
Хүргэх арга, хэлбэр	• Онлайн зээлийн үйлчилгээг санал болгодог • Зээлийн хүсэлт, материалыг онлайнаар хүлээн авч шийдвэрлэдэг • Зээл олголт, эргэн төлөлтийг бэлэн мөнгөөр хийхийг зөвшөөрдөг • Зуучлагч нараар дамжуулан зээлдэгчидтэй холбогддог	• Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нүүр тулан тогтмол гүйцэтгэдэг • Харилцагчтай шууд харилцдаг • Зээл олголт, эргэн төлөлтийг зөвхөн банкны дансаар дамжуулан хийдэг • Зуучлагч нараар дамжуулан зээлдэгчидтэй холбогддог

Газар зүйн байршил	• Өөр улс, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг • Салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг • Эдийн засгийн чөлөөт болон хилийн бүс эсвэл хяналтын тогтолцоо сул, суурь гэмт хэрэг гарах эрсдэл өндөртэй байршилд үйл ажиллагаа явуулдаг	• Хяналтыг хэрэгжүүлж бүй байгууллагатай нэг улс, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг • Салбар, төлөөлөгчийн газар байхгүй
Бүтэц, зохион байгуулалт	• ББСБ-ын эцсийн өмчлөгчид нь УТНБЭ болон бусад эрсдэлтэй өмчлөгчдөөс бүрддэг • Итгэлцлийн үйлчилгээ болон бусад хэлбэрээр хөрөнгө татан төвлөрүүлдэг • Маркетингийн үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлдэг • Жижиг байгууллага дахь МУТС эрсдэлийн талаарх ойлголт сул байж болно • Хүний нөөц дутагдалтай, хүний нөөцийн хөдөлгөөн ихтэй.	• ББСБ-ын эцсийн өмчлөгчдөд УТНБЭ болон бусад эрсдэлтэй этгээд байхгүй • Эцсийн өмчлөгчдөд шаардлага, хязгаар тавьдаг, эцсийн өмчлөгчдийг олж тогтооход хялбар • Дүрмийн сангийн шаардлага, хэмжээ бага • Маркетингийн үйл ажиллагааг хууль тогтоомжоор хязгаарладаг
Зохицуулалт	• Салбар, тухайн үйл ажиллагааг зохицуулах зохицуулалт сул эсвэл байхгүй • Төлбөр тооцоо, бүртгэлийг хянах үүрэг бүхий байгууллага байхгүй эсвэл үйл ажиллагаа нь доголдолтой	• Салбар, тухайн үйл ажиллагааг зохицуулах зохицуулалт хангалттай • Төлбөр тооцоо, бүртгэлийг хянах үүрэг бүхий байгууллага нь үр дүнтэй ажилладаг
Комплеанс	• Зээлийн эдийн засагч нарын ойлголт, мэдлэг, хандлага хангалтгүй • ББСБ-ын дотоод хяналтын тогтолцоо сул эсвэл байхгүй • Хяналт шалгалтад хамрагдаж байгаагүй • Тайлан мэдээлэл ирүүлэхгүй байх, хоцроох, тайлан мэдээллийг будилуулах, буруу гаргаж өгөх зэрэг зөрчил гаргаж байсан • Татвараас зайлсхийх, зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцож байсан түүхтэй	• МУТС эрсдэлийн талаарх зээлийн эдийн засагч нарын ойлголт, мэдлэг, хандлага хангалттай • ББСБ-ын дотоод хяналтын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлдэг • Хяналт шалгалтад хамрагдаж байсан, зөрчил дутагдал гаргаж байгаагүй • Тайлан мэдээллийг тогтмол ирүүлдэг, зөрчил дутагдал гаргаж байгаагүй • Татварын хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэг, зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцож байгаагүй

ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

490 ББСБ зээл олгох зөвшөөрөлтэй* **357** ББСБ дагнан зээл олгох үйл ажиллагаа эрхэлдэг*	**150,542** зээлдэгч* **5.1 сая** төгрөг* Нэг зээлдэгчид ногдох зээлийн өрийн үлдэгдэл	**768.3 тэрбум** төгрөг* Зээлийн өрийн үлдэгдэл **3.3%*** Зээлийн жигнэсэн дундаж хүү
433 ББСБ **575.2** тэрбум төгрөгийн зээл олгосон**	**442** ББСБ-д **444.5** тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн**	**1.3 тэрбум** төгрөг** Нэг ББСБ-д ногдох зээл олголтын дүн **1.0 тэрбум** төгрөг** Нэг ББСБ-д ногдох зээлийн эргэн төлөлтийн дүн

* 2019 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар, Эх үүсвэр: СЗХ, http://frc.mn/news/2598
** 2019 оны 2 дугаар улирлын өссөн дүнгээр, Эх үүсвэр: СЗХ, http://frc.mn/news/2598

ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	4.0	Олон тооны байгууллага ажилладаг (490 ББСБ зээл олгох зөвшөөрөлтэй, үүнээс 357 нь дагнан зээл олгох үйлчилгээг эрхэлж байна). Гэсэн хэдий ч голчлон дотоодын харилцагчдад үйлчилдэг (2019 оны 2 дугаар улирлын байдлаар гадаадын оршин суугчдаас авсан хүүгийн орлого нийт хүүгийн орлогод 0.03%-ийг эзэлж байсан)
Бүтээгдэхүүн үйлчилгээ	5.0	Бэлэн мөнгөний эргэц өндөртэй (2019 оны 2 дугаар улирлын байдлаар бэлэн мөнгө нийт эргэлтийн хөрөнгөд 10.9%-ийг эзэлж байсан)
Гүйлгээ	4.0	Гүйлгээний дүн нэмэгдэж байгаа (2019 оны 2 дугаар улирлын байдлаар нэг зээлдэгч дунджаар 5.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, нэг ББСБ дунджаар 1.0 тэрбум төгрөгийн зээл олгосон). Зөвхөн дотоодод гүйлгээ хийгддэг.
Харилцагч	3.0	Дийлэнх харилцагчид нь дотоодын иргэд байдаг. Гадаадын хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж байгаа.
Хүргэх суваг	2.0	Ихэнх тохиолдолд харилцагчтай шууд нүүр тулж харилцдаг
Дундаж оноо	**3.6**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	4.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дундаас дээш (2019 оны 2 дугаар улирлын байдлаар 150.5 мянган зээлдэгчийн 768.3 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй олгосон)
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	3.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дунд зэрэг (хадгаламж татан төвлөрүүлдэггүй хэдий ч, арилжааны банкууд хэрэглээний зээлээ хумиж байгаатай холбогдуулан ББСБ-ын зээлийн эрэлт нэмэгдэж байгаа.)
Дундаж оноо	**3.5**	

Эрсдэлийн түвшин	**12.6**

8.1.2. Факторингийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Бага | Дунджаас доош | Дунджаас дээш | Өндөр

Зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагаа



Факторингийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-ын хувьд үүрэг гүйцэтгүүлэгчээс факторингийн хүсэлт хүлээн авч (2) шийдвэрлэх шатанд харилцагчдыг буюу үүрэг гүйцэтгүүлэгч (худалдагч - нийлүүлэгч) болон захиалагч – худалдан авагч хоёр талыг аль алиныг нь таньж мэдэх ажиллагааг явуулах шаардлагатай. Ингэхдээ өмнөх зээлийн үйлчилгээний хувьд харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой дурдсан нийтлэг зүйлсээс гадна дараах зүйлсэд анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

1. Бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх гэрээний хоёр тал нь хоорондоо холбогдох этгээд эсэх.
2. Гэрээний хоёр талын бизнесийн үйл ажиллагааны онцлог нь гэрээний зүйл буюу нийлүүлэх бараа, ажил үйлчилгээтэй уялдаатай эсэх.

Факторингийн хүсэлтийг зөвшөөрөх (3) шатанд бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх гэрээний хугацаа нь бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх боломжит хугацаанаас богино эсэх, гэрээний

нөхцөлд эдийн засаг, хууль эрх зүйн үндэслэлгүй зүйл байгаа эсэхийг хянан үзэх, үүрэг гүйцэтгүүлэгч факторингийн гэрээний урьдчилсан төлбөрийн хувь, факторингийн үйлчилгээний төлбөр зэрэгт төдийлөн анхаарал хандуулахгүй байвал тусгайлсан хяналт тавих шаардлагатай.

ББСБ-ын факторингийн үйл ажиллагаан дахь төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлс

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Гэрээний хоёр тал холбогдох этгээдүүд байх • Захиалагч – худалдан авагч тал гадаадын иргэн, хуулийн этгээд • Гэрээний хоёр талын бизнесийн үйл ажиллагааны онцлог нь гэрээний зүйлтэй хамааралгүй байх.	• Гэрээний хоёр тал хамааралгүй этгээдүүд байх • Захиалагч – худалдан авагч тал дотоодын иргэн, хуулийн этгээд • Гэрээний хоёр талын бизнесийн үйл ажиллагааны онцлог нь гэрээний зүйлтэй хамааралтай.
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Төлбөрийг шууд 100% эсвэл 85%-аас дээш хувийг урьдчилан төлдөг • Факторингийн гэрээний төлбөр бага • Факторингийн гэрээний төлбөр өндөр хэдий ч гэрээний нөхцөл нь уян хатан • Факторингийн дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодог	• Урьдчилгаа төлбөрт 85%-аас доош хувийг шилжүүлдэг • Хөрвөх чадвар бага, хатуу нөхцөлтэй, хугацаанаас өмнө төлбөр төлөхийг зөвшөөрдөггүй. • Факторингийн дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодоггүй
Хүргэх арга, хэлбэр	• Зуучлагчаар дамжуулан факторингийн гэрээ байгуулдаг • Үүрэг гүйцэтгүүлэгчийг биечлэн ирэхийг шаарддаггүй	• Зуучлагч оролцуулдаггүй • Үүрэг гүйцэтгүүлэгчийг биечлэн ирэхийг шаарддаг
Газар зүйн байршил	• Төлбөр хүлээн авагч нь өөр улс, орон нутагт байрладаг • Гэрээгээр нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ нь хил дамнасан	• Төлбөр хүлээн авагч нь нэг улс, орон нутагт байрладаг • Гэрээгээр нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ нь өөр байршилд байдаггүй

Бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, комплеансын үзүүлэлтийн хувьд нийтлэг байдлаар авч үзэх хэрэгтэй (БҮЛЭГ 3-ыг үзнэ үү).

ББСБ-ын факторингийн үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд

2 ББСБ факторингийн үйлчилгээ үзүүлж байна*

8,134.2 сая төгрөг*
Факторингийн авлага

** 2018 оны 2 дугаар улирлын байдлаар, Эх үүсвэр: СЗХ-ны ББСБ-ын газар.

ББСБ-ын факторингийн үйлчилгээний эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	2.0	Факторингийн үйлчилгээний харилцагчдын тоо цөөн (24 ББСБ факторингийн үйлчилгээний зөвшөөрөлтэй хэдий ч 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 2 ББСБ факторингийн үйлчилгээ үзүүлжээ).
Бүтээгдэхүүн үйлчилгээ	4.0	Факторингийн гэрээ нь харилцагчийг таньж мэдэх, харилцагчдын бизнесийн харилцаа, гэрээний мөн чанарыг тодорхойлоход харьцангуй төвөгтэй. Гэхдээ гүйлгээг зөвхөн арилжааны банкин дахь дансаар дамжуулан хийдэг.
Гүйлгээ	4.0	Гүйлгээний дүн харьцангуй өндөр. Зөвхөн 2 ББСБ факторингийн үйлчилгээ үзүүлсэн хэдий ч тэдний факторингийн өглөгийн дүн нийт ББСБ-ын өглөгийн дүнд 2.2%-ийг эзэлж байна.
Харилцагч	4.0	Харилцагчид дотоод болон гадаадын харилцагчид байдаг.
Хүргэх суваг	2.0	Харилцагчтай шууд нүүр тулж харилцдаг хэдий экспорт, импортын факторингийн нөхцөлд гадаад дахь талыг таньж мэдэхэд хүндрэл үүсэх талтай
Дундаж оноо	**3.2**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	1.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө бага (2019 оны 2 дугаар улирлын байдлаар 2 ББСБ 8.1 тэрбум төгрөгийн факторингийн өглөгтэй байна)
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	3.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дунд зэрэг (энэ төрлийн үйлчилгээний талаарх мэдлэг ойлголт бага, МУТС үйлдэл илэрсэн тохиолдолд энэ үйл ажиллагаанд улам илүү сөрөг нөлөөг үзүүлэх болно)
Дундаж оноо	**2.0**	

Эрсдэлийн түвшин	**6.4**

8.1.3. Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл



Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасан (4.1.4), баталгааны гэрээгээр ББСБ нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч ББСБ-д төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ



Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэгч ББСБ-ын хувьд баталгаа гаргуулагчаас баталгааны хүсэлт хүлээн авч (2) шийдвэрлэх шатанд харилцагчдыг буюу баталгаа гаргуулагч болон баталгаа хүлээн авагч хоёр талыг аль алиныг нь таньж мэдэх ажиллагааг явуулах шаардлагатай. Ингэхдээ харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой дурдсан нийтлэг зүйлсээс гадна дараах зүйлсэд анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

3. Гэрээний хоёр тал нь хоорондоо холбогдох этгээд эсэх.
4. Гэрээний хоёр талын бизнесийн үйл ажиллагааны онцлог нь гэрээний зүйлтэй уялдаатай эсэх.

Гэрээний нөхцөл нь эдийн засаг, хууль эрх зүйн үндэслэлгүй, баталгаа гаргуулагч нь төлбөрийн баталгааны шимтгэл зэрэгт төдийлөн анхаарал хандуулахгүй байвал тусгайлсан хяналт тавих шаардлагатай.

ББСБ-ын төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаан дахь төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлс

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Гэрээний хоёр тал холбогдох этгээдүүд байх • Баталгаа хүлээн авагч тал гадаадын иргэн, хуулийн этгээд • Гэрээний хоёр талын бизнесийн үйл ажиллагааны онцлог нь гэрээний зүйлтэй хамааралгүй байх.	• Гэрээний хоёр тал хамааралгүй этгээдүүд байх • Баталгаа хүлээн авагч тал дотоодын иргэн, хуулийн этгээд • Гэрээний хоёр талын бизнесийн үйл ажиллагааны онцлог нь гэрээний зүйлтэй хамааралтай.
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Төлбөрийн баталгааны шимтгэл бага • Төлбөрийн баталгааны шимтгэл өндөр хэдий ч гэрээний нөхцөл нь уян хатан • Төлбөрийн баталгааны дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодог	• Хөрвөх чадвар бага, хатуу нөхцөлтэй, хугацаанаас өмнө төлбөр төлөхийг зөвшөөрдөггүй. • Төлбөрийн баталгааны дүнгээс шалтгаалж хямдрал, урамшуулал санал болгодоггүй
Хүргэх арга, хэлбэр	• Зуучлагчаар дамжуулан төлбөрийн баталгаа гаргадаг • Баталгаа гаргуулагчийг биечлэн ирэхийг шаарддаггүй	• Зуучлагч оролцуулдаггүй • Баталгаа гаргуулагчийг биечлэн ирэхийг шаарддаг
Газар зүйн байршил	• Баталгаа хүлээн авагч нь өөр улс, орон нутагт байрладаг • Гэрээгээр нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ нь хил дамнасан	• Баталгаа хүлээн авагч нь нэг улс, орон нутагт байрладаг • Гэрээгээр нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ нь өөр байршилд байдаггүй

Бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, комплеансын үзүүлэлтийн хувьд нийтлэг байдлаар авч үзэх хэрэгтэй (БҮЛЭГ 3-ыг үзнэ үү).

ББСБ-ын төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

19 ББСБ төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээг үзүүлж байна*

** 2018 оны 2 дугаар улирлын байдлаар, Эх үүсвэр: СЗХ-ны ББСБ-ын газар.

ББСБ-ын төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	1.0	Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ авсан харилцагч одоогоор байхгүй (19 ББСБ төлбөр баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэй хэдий ч 2019 оны 2 дугаар улирлын байдлаар нэг ч ББСБ энэ төрлийн үйлчилгээ үзүүлээгүй байна).
Бүтээгдэхүүн үйлчилгээ	3.0	Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээний гэрээ нь харилцагчийг таньж мэдэх, харилцагчдын бизнесийн харилцаа, гэрээний мөн чанарыг тодорхойлоход харьцангуй төвөгтэй. Гэхдээ гүйлгээг зөвхөн арилжааны банкин дахь дансаар дамжуулан хийдэг.
Гүйлгээ	1.0	Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ авсан харилцагч одоогоор байхгүй
Харилцагч	1.0	Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ авсан харилцагч одоогоор байхгүй
Хүргэх суваг	1.0	Харилцагчтай шууд нүүр тулж харилцдаг
Дундаж оноо	**1.4**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	1.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө бага (Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ авсан харилцагч одоогоор байхгүй)
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	3.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дунд зэрэг (энэ төрлийн үйлчилгээний талаарх мэдлэг ойлголт бага, МУТС үйлдэл илэрсэн тохиолдолд энэ үйл ажиллагаанд улам илүү сөрөг нөлөөг үзүүлэх болно)
Дундаж оноо	**2.0**	

Эрсдэлийн түвшин	**2.8**

8.1.4. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдан гарсан. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.23-д ""төлбөрийн хэрэгсэл" гэж бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг Монголбанкны зөвшөөрөл бүхий биет, биет бус хэрэгслийг", 5.1.25-д ""цахим мөнгө" гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгслийг" тус тус ойлгоно гэж заасан. Мөн хуулийн 10.1-д төлбөрийн хэрэгсэл гаргах, цахим мөнгө гаргах үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг Монголбанк олгоно гэж заасан байдаг.

Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуульд заасны дагуу СЗХ-ноос **төлбөр, тооцооны хэрэгсэл гаргах** тусгай зөвшөөрөл авсан **3 ББСБ** байна. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу төлбөрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг Монголбанк хэрэгжүүлж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.7-д төлбөрийн хэрэгсэл гаргах, цахим мөнгө гаргах үйл ажиллагааг эрхлэх этгээд энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичгийг ирүүлнэ гэж заажээ.

Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагааны хувьд гаргасан төлбөр тооцооны хэрэгслийг ашиглан бага дүнтэй хянагдах боломжгүй олон тооны гүйлгээг хийх, харилцагч цахим төхөөрөмжийн нууцлалыг бусдад ашиглуулах, алдах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотоод хяналтын тогтолцоог зөрчих зэргээр МУТС эрсдэл үүсэх магадлалтай.

Типологи жишээ #3 (Төлбөрийн хэрэгсэл ашиглах - Япон улс):

Хуучин барааны худалдаа эрхлэгч, мөн хууль бус зээл олгогч нэгэн этгээд зээлийн картын компанийг залилж, харилцагчдын зээлийн картыг ашиглан хууль бус ашиг олохоор төлөвлөжээ. Худалдаа эрхлэгч хэзээ ч хийгдээгүй зээлийн картаар төлөгдсөн борлуулалтыг тайлагнасан борлуулалтын зохиомол мэдээллийг зээлийн картын компанид хүргүүлжээ. Зээлийн картын компани өөр хүний нэр дээр нээгдсэн, гэхдээ үнэндээ худалдаа эрхлэгчийн хяналтан дахь данс руу мөнгийг шилжүүлж байжээ.

ББСБ-ын төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	1.0	Цөөн тооны байгууллага ажилладаг (3 ББСБ төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй). Нөгөө талаас голчлон дотоодын харилцагчдад үйлчилдэг.
Бүтээгдэхүүн үйлчилгээ	2.0	Гүйлгээний тоо олон боловч, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу хянагдах бүрэн боломжтой.
Гүйлгээ	2.0	Бага дүнтэй гүйлгээг зөвхөн дотооддоо хийдэг.
Харилцагч	4.0	Харилцагчдын тоо олон.
Хүргэх суваг	4.0	Харилцагчтай нүүр тулж харилцдаггүй.
Дундаж оноо	**2.6**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	3.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дунд зэрэг (энэ төрлийн төлбөр тооцооны хэрэгсэл ашиглагчдын тоо олон, идэвхжиж байгаа үйл ажиллагаа)
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	4.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дундаас дээш (шинэ тутам хөгжиж буй салбарын нэр хүндэд улам илүү сөрөг нөлөөг үзүүлэх болно)
Дундаж оноо	**3.5**	

Эрсдэлийн түвшин	**9.1**

8.1.5. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагаа (4.1.5)

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.21-д ""мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг" гэж харилцагчаас цахим төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид хандаж эхлүүлсэн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг", 5.1.22-д ""мөнгөн гүйвуулга"

гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг" тус тус ойлгоно гэж заасан. Мөн хуулийн 10.1-д мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг Монголбанк олгоно гэж заасан байдаг.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу төлбөрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг Монголбанк хэрэгжүүлж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.7-д мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх үйл ажиллагааг эрхлэх этгээд энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичгийг ирүүлнэ гэж заажээ.

Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуульд заасны дагуу СЗХ-ноос **цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ** эрхлэх тусгай зөвшөөрөл авсан **27 ББСБ** байна.

Цахим төлбөр тооцооны үйлчилгээг ашиглан бага дүнтэй хянагдах боломжгүй олон тооны гүйлгээг хийх, харилцагч цахим төхөөрөмжийн нууцлалыг бусдад ашиглуулах, алдах, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотоодын хяналтын тогтолцоог зөрчих МУТС эрсдэл үүсэх магадлалтай. Бүртгэл, гүйлгээг харилцагчтай нүүр тулахгүйгээр хийж байгаа нь харилцагчийг таньж мэдэх шатанд эрсдэлийг үүсгэнэ.

Типологи жишээ #4 (Цахим төлбөрийн хэрэгсэл ашиглах - Хятад улс):

2017 оны 6 дугаар сард сэжигтэн D өөрийн Alipay QR кодыг таних нэрийн хамт мансууруулах бодис борлуулсан орлогоо хүлээн авахад нь найз охин (гэмт хэрэгт холбогдон, ял шийтгүүлсэн)-доо өгч ашиглуулж, найз охиныхоо тоглоомын ID руу мөнгийг шилжүүлсэн. Сэжигтэн D гэмт хэрэг үйлдэж олсон орлогын эх үүсвэр, төлөв байдлыг нуухад өөрийн дансыг ашиглаж, мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон. 2018 оны 4 сард сэжигтэн D-д шүүхээс хоёр сар тэнсэн харгалзах, торгууль төлөх ял оноожээ.

Типологи жишээ #5 (Цахим төлбөрийн хэрэгсэл ашиглах - Хятад улс):

2017 онд сэжигтэн E мансууруулах бодис худалдсан хэрэгт холбогдсон бөгөөд мансууруулах бодисын төлбөрийг WeChat ашиглан мөн бэлэн мөнгөөр нь хүлээж авчээ.Сэжигтэн E ижил арга замаар мөнгийг өмнөх эхнэр (Сэжигтэн F) рүүгээ шилжүүлжээ. Шүүхээс сэжигтэн F өөрийн WeChat дансыг сэжигтэн E-д өгч, гэмт хэрэг үйлдэж олсон орлогын эх үүсвэр, төлөв байдлыг нуух үйлдэл хийсэн, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг шилжүүлэхэд тусалсан гэж үзсэн. Тэд хамтдаа мөнгө угаасан гэмт хэрэгт холбогдсон. 2018 оны 3 дугаар сард шүүхээс сэжигтэн F-д 7 сар хорих, торгууль төлөх ял оноосон.

Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны хувьд харилцагч гэдэгт мөнгө шилжүүлэгч болон мөнгө хүлээн авагч хоёр талыг аль алиныг нь хамруулан авч үзнэ. Мөнгө гуйвуулгыг

гүйцэтгэхийн өмнө **харилцагчийг таньж мэдэхэд тусгайлан хяналт тавих хэрэгтэй**. Үүнд: улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улс (ФАТФ-аас гаргасан хориг арга хэмжээ авах улс орнуудын "хар жагсаалт" болон МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой улс орнуудын "саарал жагсаалт")-ын иргэн болон ААНБ, НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл эсэхийг нягтлах шаардлагатай.

Мөнгө гуйвуулгын **бүтээгдэхүүн, үйлчилгээний** хувьд дараах хүчин зүйлс МУТС эрсдэлийг нэмэгдүүлэх болно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

1. Өндөр дүнтэй гуйвуулгыг хүлээн зөвшөөрдөг.
2. Мөнгө гуйвуулгыг шилжүүлэх улс орны тоо, хамрах хүрээ өргөн.
3. Гүйлгээний маягт бөглөх шаардлагагүй, ББСБ биечлэн ирэх шаардлагагүй.
4. Гуйвуулгыг гүйцэтгэх хугацаа хурдан.
5. Олон төрлийн валютаар гүйлгээ хийх боломжтой.
6. Шимтгэлийн дүн бага.
7. Олон улсын нэртэй мөнгөн гуйвуулгын сүлжээтэй хамтардаг.

Типологи жишээ #6 (Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ - Пакистан улс):

ABC мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч компани хүүхдийн хүчирхийллийн видео хийж, онлайнаар зарж байсан гэмт хэрэгт холбогдсон сэжигтний талаарх мэдээлэл цацагдсныг үндэслэн сэжигтэн XYZ-тэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайланг илгээсэн. Сэжигтэн XYZ-ийг Холбооны мөрдөх товочооноос баривчилсан байсан. Гадаадын цагдаагийн байгууллага хүүхдийн хүчирхийллийн үйл ажиллагаатай холбоотой нэг хүнийг баривчилсан. Мөрдөн байцаах ажиллагааны явцад сэжигтэн Пакистан улсын иргэн, сэжигтэн XYZ мөн хууль бус үйл ажиллагаанд оролцсон гэдгийг илчилсэн. Уг мэдээллийг гадаад улсын элчин сайдын яамнаас Пакистан улсын хууль сахиулагчдад өгч, уг мэдээлэлд үндэслэн түүнийг баривчилсан.

Сэжигтэн XYZ олон тооны хүнээс 6 улсаас бага дүнтэй гуйвуулгыг хүлээн авсан байдаг. Сэжигтэн XYZ видеог борлуулснаас олсон хууль бус орлогыг хүлээн авсан хэрэгт сэжиглэгдсэн. Сэжигтэн тэрээр мөн нэг видео борлуулахад бага хэмжээний мөнгө авдаг байснаа илчилжээ.

Пакистан улсын CMA хууль сахиулах байгууллагатай хамтран шалгалт хийсэн. Сэжигтэн кибер гэмт хэрэгт буруутгагдан, тусгай шүүхээс 7 жил хорих, 1.2 сая рупигийн торгууль төлөх ял ногдуулжээ.

ББСБ-ын цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	3.0	Харьцангуй олон тооны байгууллага ажилладаг (27 ББСБ цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй). Нөгөө талаас мөнгөн гуйвуулгын үйлчилгээний хүлээн авагчид гадаад улс дахь харилцагчид байдаг.
Бүтээгдэхүүн үйлчилгээ	4.0	Цахим төлбөр тооцооны гүйлгээний тоо олон боловч Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу хянагдах бүрэн боломжтой. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйлчилгээ учир МУТС магадлал өндөртэй
Гүйлгээ	3.0	Их дүнтэй гүйлгээг гадаад улс руу хийх боломжтой
Харилцагч	4.0	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад улс руу хийгддэг
Хүргэх суваг	4.0	Харилцагчтай нүүр тулж харилцдаггүй.
Дундаж оноо	**3.6**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	2.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дунд зэрэг (цахим төлбөр тооцооны үйл ажиллагаа идэвхжиж байгаа хэдий ч арилжааны банкны үйлчилгээ давамгайлж байгаа)
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	3.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дунд зэрэг (гадаад улс орнуудтай харилцдаг, арилжааны банкаар гүйцэтгэх боломжтой)
Дундаж оноо	**2.5**	

Эрсдэлийн түвшин	**9.0**

8.1.6. Гадаад валютын арилжаа эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Бага	Дунджаас доош	Дунджаас дээш	Өндөр

Гадаад валютыг худалдах, худалдан авах, түүгээр зээл олгох, баталгаа гаргах үйл ажиллагаа (4.1.6)

Олон улсад гадаад валютын арилжаагаар дамжуулан мөнгө угаах нь гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус эх үүсвэрийг нуух, улмаар хууль ёсны санхүүгийн урсгалд нэгтгэх хамгийн үр нөлөөтэй арга гэж үздэг. Валют арилжааны цэг нь мөнгө угаахад шууд ашиглагддаггүй мэт харагдах боловч бохир мөнгийг хууль ёсны мэт болгоход чиглэсэн олон шат дамжлагад оруулах, тухайн улс орны санхүүгийн системд байршуулах эхний үе шат болдог.

Валют арилжааны үйл ажиллагаагаар дамжуулан мөнгө угаах голчлон тохиолддог хэлбэрт:

- **Их хэмжээний бэлэн мөнгийг өөр валют руу шилжүүлэх.** Энэ нь зохион байгуулалттай гэмт хэргээс үүсэлтэй мөнгө байх магадлалтай. Гэмт хэрэг үйлдэж олсон их хэмжээний бэлэн мөнгөтэй хүн банканд хандахгүйгээр шууд валют арилжааны цэгт очиж, гадаад валютаар солиулдаг. Валют арилжааны цэгийн ажилтан ихэнхдээ ийм төрлийн харилцагчийг таньж мэдэж чаддаггүй.
- **Бага дүнтэй бэлэн мөнгөний олон тооны гүйлгээгээр дамжуулан валют арилжих**. Их дүнтэй арилжааг олон тооны жижиг гүйлгээгээр дамжуулан хийдэг болох нь тодорхой болсон байдаг. МУТСТ тухай Монгол Улсын хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг хийж буй харилцагчийг таньж мэдэх, мэдээлэх шаардлагаас зайлсхийхийн тулд ийм үйлдлийг хийдэг. Ийм төрлийн гүйлгээг ихэвчлэн нэгээс олон тооны валют арилжааны цэгээр дамжуулан хийдэг. Хэд хэдэн хүнд бага хэмжээний төлбөр өгч эдгээр гүйлгээг хийлгэх тохиолдол байдаг.
- **Валют арилжааны цэг дээр бодит байдал дээр хэрэгжих боломжгүй олон тооны гүйлгээ хийгдсэн байх.** Тухайн валют арилжааны цэг дээр маш богино хугацаанд олон тооны гүйлгээ хийгдсэн тайлан мэдээлэл ирж болно. Энэ нь олон тооны бага дүнтэй гүйлгээгээр их хэмжээний бэлэн мөнгийг арилжих зорилготой хэдий ч гүйцэтгэсэн хугацааг нь авч үзвэл техникийн хувьд боломжгүй байдаг.
- **Нэг гадаад валютаас нөгөө гадаад валют руу арилжаа хийх.** Монгол Улсад энэ гүйлгээг хийхийн тулд эхлээд гадаад валютыг төгрөгт шилжүүлээд дараа нь төгрөгөө өөр нэг гадаад валют руу шилжүүлэх хэрэгтэй болно. Харилцагчийн хувьд эдгээр гүйлгээ нь алдагдалтай бөгөөд эдийн засгийн хувьд ач холбогдолгүй хэдий ч мөнгө угаагчдын хувьд аливаа боломжит хэлбэрээр хөрөнгийн эх үүсвэрийг нуух зорилготой учраас энэ нь чухал биш юм.
- **Тодорхой гэмт хэргийн үйл ажиллагаанд ашиглагддаг мөнгөн тэмдэгтийн арилжаа.** Зарим улс оронд зохион байгуулалттай гэм хэрэгт ашиглагддаг учраас

валют арилжааны цэгүүдийг 500 еврогийн мөнгөн тэмдэгтийг арилжихыг зогсоохыг зөвлөсөн байдаг. Гэмт хэрэгтнүүд өндөр дүнтэй мөнгийг цөөн тооны гүйлгээгээр мөнгө угаах боломжтой учраас энэ төрлийн мөнгөн тэмдэгт нь тэдний ашиглах дуртай мөнгөн тэмдэгтүүд юм. Түүнчлэн, овор хэмжээ багатай учраас тээвэрлэхэд хялбар байдаг.

- **Тэмдэгтэй мөнгөн тэмдэгтийг арилжих.** Гадаадын мөнгөн тэмдэгттэй харилцахдаа МУТС үйл ажиллагаатай холбоотой хувь хүн эсэхийг таньж болох тэмдэгтэй мөнгөн тэмдэгтэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Эдгээр тэмдэг нь тусгай бодисоор бичигддэг учраас шууд таних боломжгүй, зөвхөн хэт ягаан туяаны гэрэлд харагддаг байж болно.
- **Гэмтсэн мөнгөн тэмдэгтийг арилжих.** Гэмт хэргийн үйл ажиллагааны улмаас гэмтсэн мөнгөн тэмдэгтийг арилжаанд оруулж болох учраас мөнгөн тэмдэгтийн гэмтлийн төрөл, гэмтсэн арга замыг анхааралдаа авах шаардлагатай. Мөнгөн тэмдэгтүүдийг зориуд гэмтээсэн байж болно. Зөвхөн бодит эх үүсвэрийг нь нуун далдлах зорилготой гэмт хэрэгтний хувьд төдийлөн чухал биш учраас ихээхэн төлбөртэйгөөр эдгээр мөнгөн тэмдэгтийг сольдог.

Арилжааны өмнө	Арилжааны үед
Харилцагчийг таньж мэдэх: - иргэний үнэмлэх, гадаад паспорт зэрэг бичиг баримтыг үзэж шалгах (НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалт). - гадаадын иргэн бол аль улсын иргэн болохыг тодорхойлох. - бичиг баримтаа үзүүлэхээс татгалзвал үйлчилгээ үзүүлэхээс татгалзах.	Гүйлгээний зорилго, дүн, мөнгөн тэмдэгт зэргийг шалгах - Их дүнтэй арилжаа. - Том дүнтэй мөнгөн тэмдэгт худалдан авах хүсэлт. - Гадаад валют зараад өөр гадаад валют авах хүсэлт. - Нийтлэг арилжигддаг валютаас өөр төрлийн, гадаадад зорчоод ирэхэд үлдэж болох (leftover) дүнгээс их дүнтэй валютын арилжаа - Тэмдэгтэй болон гэмтэлтэй мөнгөн тэмдэгтийн арилжаа гэх мэт.

ББСБ-ын гадаад валютын арилжааны үйл ажиллагаан дахь төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлс

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Голчлон арилжааны банк, ААНБ-тай арилжаа хийдэг • Олон тооны харилцагч үйлчлүүлдэг	• Голчлон иргэдтэй арилжаа хийдэг • Цөөн тооны тодорхой харилцагчтай
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Харилцагчийг таньж мэдэж, бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй • Олон төрлийн валютын арилжаа эрхэлдэг • Арилжих валютын дүнгээс шалтгаалж ханшийг уян хатан өөрчилдөг	• Харилцагчийг таньж мэдэж, бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй • Цөөн тооны нийтлэг арилжигддаг валютын арилжаа эрхэлдэг • Арилжих валютын дүнгээс үл хамааран ханшийг хөдөлгөдөггүй
Хүргэх арга, хэлбэр	• Дуудлагаар харилцагчийн байранд очиж үйлчилгээ үзүүлдэг	• Зөвхөн валют арилжааны цэг дээр арилжаа хийдэг
Газар зүйн байршил	• Орон нутагт, хилийн боомт дээр үйл ажиллагаа явуулдаг • Салбар, төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг	• Нийслэлд, төвлөрсөн нэг цэгт үйл ажиллагаа явуулдаг
Комплеанс Бүтэц, зохион байгуулалт	• Ажилтнуудын МУТС-тэй холбоотой ойлголт, мэдлэг, хандлага хангалтгүй • Харилцагч, гүйлгээ бүрийг бүртгэдэггүй, мэдээллийн сан үүсгэдэггүй • Том дүнтэй мөнгөн дэвсгэртийн арилжаанд хязгаарлалт тавьдаггүй • Тэмдэгтэй, гэмтсэн мөнгөн тэмдэгтийн арилжаанд анхаарал хандуулдаггүй • Хамгаалалтын камер зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон	• Ажилтнуудын МУТС-тэй холбоотой ойлголт, мэдлэг, хандлага хангалттай • Харилцагч бүрийг болон гүйлгээ бүрийг бүртгэх программ хангамж, мэдээллийн сантай • Том дүнтэй мөнгөн дэвсгэртийн арилжаанд хязгаарлалт тавьдаг • Тэмдэгтэй, гэмтсэн мөнгөн тэмдэгтийн арилжаанд анхаарал хандуулдаг • Хамгаалалтын камер зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй

Бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, комплеансын үзүүлэлтийн хувьд мөн нийтлэг байдлаар авч үзэх хэрэгтэй (БҮЛЭГ 3-ийг үзнэ үү).

Типологи жишээ #7 (Мэдүүлээгүй валютын арилжаа - Фижи улс):

СМА Z улс руу тогтмол зорчдог Фижи улсын иргэн болсон М гэж хүнтэй холбоотой СГТ-г гадаад валютын арилжаа эрхлэгчээс хүлээн авсан. М гэж хүн Х болон Y гэж хүний өмнөөс 30,000.00 очим Фижи долларын дүнтэй 3 удаагийн гадаад валютын арилжаа хийжээ. Фижи улсын СМА санхүүгийн шалгалт хийж, уг 30,000.00 Фижи доллар нь М, Х, Y зэрэг хүмүүсийн банкны данснаас гараагүй болохыг олж тогтоожээ. Эдгээр хүмүүс мөнгийг гэртээ бэлнээр хадгалж, мөнгө угаах зорилготой байсан гэж сэжиглэгдсэн. Уг хэргийг Фижи улсын Орлого, гаалийн албанд мөрдөн байцаалтанд шилжүүлсэн. Энд: Гаалийн мэдүүлэг гаргаагүй, мөнгө угаасан, татвараас зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэгдсэн байх магадлалтай. Тодорхойлох үзүүлэлт нь: гаалийн мэдүүлэг бөглөөгүй, бусад хүний нэрээр мөнгийг хувиараа арилжсан.

Гадаад валют арилжааны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

154 ББСБ гадаад валютын арилжаа*

Үүнээс: **6** ББСБ орон нутагт

44 ББСБ*
Гадаад валютын арилжааг дагнан

25 ББСБ*
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээтэй

110 ББСБ*
Зээлийн болон бусад үйлчилгээтэй хамт эрхэлж байна

* 2018 оны жилийн эцсийн байдлаар
** Эх үүсвэр: СЗХ-ны ББСБ-ын газар.

ББСБ-ын гадаад валют арилжааны үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	4.0	Харьцангуй олон тооны байгууллага ажилладаг (154 ББСБ гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй).
Бүтээгдэхүүн үйлчилгээ	4.0	Үйлчилгээний хувьд энгийн боловч шууд бэлэн мөнгөөр олон тооны гүйлгээг хийдэг.
Гүйлгээ	2.0	Гүйлгээний дүн харьцангуй бага, дотооддоо хийгддэг
Харилцагч	4.0	Гадаад, дотоодын олон тооны харилцагч үйлчлүүлдэг.
Хүргэх суваг	4.0	Харилцагчтай нүүр тулж харилцдаг хэдий ч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй.
Дундаж оноо	**3.6**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	2.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дундаас доош (гадаад валютын ханш өсөхөд нөлөөлж болох хэдий ч дунд, урт хугацаандаа нөлөө багатай)
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	2.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дундаас доош (харилцагчид арилжааны банкаар үйлчлүүлэх боломжтой)
Дундаж оноо	**2.0**	

Эрсдэлийн түвшин	**7.2**

8.1.7. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаа (4.1.7)

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах (1) шатанд харилцагч буюу итгэмжлэгч болон хэрэв хувь хүртэгч байгаа бол хувь хүртэгчийг таньж мэдэхэд дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Итгэмжлэгч болон хувь хүртэгчид нь улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл эсэх, итгэмжлэгч болон хувь хүртэгчдийн хоорондох холбоо хамаарлыг нягтлах.
2. Итгэмжлэгчийн шинж чанар: Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг эсэх.

3. Итгэмжилсэн хөрөнгийн шинж чанар: тухайн хүн, хуулийн этгээдийн эрхэлж буй ажил, үйл ажиллагааны чиглэл нь итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой эсэх, итгэмжилсэн хөрөнгийн эх үүсвэр, хөрөнгийн төлөв байдлыг нягтлах.

Түүнчлэн итгэмжилсэн хөрөнгө нь бэлэн мөнгө бөгөөд хөрөнгийг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлэх (2), хөрөнгийг итгэмжлэгчийн удирдлагад буцаан шилжүүлэх (4)-дээ бэлнээр хүлээлгэн өгөх нь эрсдэлийг нэмэгдүүлнэ. Хөрөнгийг итгэмжлэгчийн удирдлагад буцаан шилжүүлэхэд хувь хүртэгч эсвэл өөр бусад этгээдэд шилжүүлэх нь МУТС эрсдэлийг нэмэгдүүлнэ.

Итгэлцлийн үйлчилгээн дэх төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлс

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), • МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, • НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл • Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг этгээд, • Итгэмжлэгчийн эрхэлж буй ажил, үйл ажиллагааны чиглэл нь итгэмжилсэн хөрөнгөтэй холбоогүй, • Итгэмжилсэн хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй • Итгэмжлэгч болон хувь хүртэгч нь хоорондоо тодорхой хамааралгүй	• Цөөн тооны тодорхой харилцагчтай • Харилцагч буюу итгэмжлэгч нь тусгайлан хяналт тавих этгээд биш (өмнөх нүдэнд дурдсан этгээд биш) • Итгэмжилсэн хөрөнгийн эх үүсвэр тодорхой, итгэмжлэгчийн ажил, үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Итгэмжилсэн хөрөнгө нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө • Хөрөнгийг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлэх, итгэмжлэгчид буцаан шилжүүлэхдээ бэлэн мөнгөний гүйлгээ хийхийг зөвшөөрдөг • Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа харьцангуй богино • Гэрээний нөхцөл уян хатан, хугацаанаас өмнө цуцлах,	• Итгэмжилсэн хөрөнгө нь бэлэн мөнгөнөөс бусад актив • Хөрөнгийн гүйлгээ болон ашиг (үр шим) хүртээхдээ зөвхөн банкны данс эсвэл зохицуулалтай төлбөр, тооцооны систем ашигладаг • Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа харьцангуй урт

	хэсэгчлэн буцаан авах боломжтой • Хувь хүртэгч оролцсон, ялангуяа нэгээс олон тооны хувь хүртэгч оролцсон • Гэрээний хугацаа дуусахад итгэмжилсэн хөрөнгийг хувь хүртэгч эсвэл гуравдагч этгээдэд шилжүүлэх.	• Гэрээний нөхцөл хатуу, хугацаанаас өмнө цуцлах боломжгүй • Итгэмжилсэн хөрөнгийг зөвхөн итгэмжлэгч өөрөө эргүүлэн авах.
Хүргэх арга, хэлбэр	• Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг гуравдагч этгээдээр дамжуулан хийх боломжтой	• Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг гуравдагч этгээдээр дамжуулан хийх боломжгүй
Газар зүйн байршил	• Итгэмжлэгч нь гадаад улсаас эсвэл өөр байршлаас харилцаж байгаа • Салбар, төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг	• Итгэмжлэгч болон итгэмжлэгдэгч ББСБ нэг улс, байрлалд байгаа

Бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, комплеансын үзүүлэлтийн хувьд нийтлэг байдлаар авч үзэх хэрэгтэй (БҮЛЭГ 3-ыг үзнэ үү).

ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд

31 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй **1** ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна	**24** ББСБ 2018 онд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан **3.5 тэрбум** төгрөг Нэг ББСБ ногдох гэрээний дүн	**84.1 тэрбум** төгрөг Өглөгийн эцсийн үлдэгдэлтэй **73.9%** Өглөгийн эцсийн үлдэгдлийн өөрийн хөрөнгөнд эзлэх хувь

** 2018 оны 2 дугаар улирлын байдлаар, Эх үүсвэр: СЗХ-ны ББСБ-ын газар.

ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	4.0	Харьцангуй олон тооны байгууллага ажилладаг (31 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 24 ББСБ итгэлцлийн гэрээ байгуулсан).
Бүтээгдэхүүн үйлчилгээ	4.0	Үйлчилгээний хувьд энгийн боловч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд эрсдэл өндөртэй. Мөнгөн дүн харьцангуй өндөр (2019 оны 2 дугаар улирлын байдлаар итгэлцэл татсан ББСБ-ын дунджаар өөрийн хөрөнгийн 79%-тай тэнцэх, дунджаар 3.5 тэрбум төгрөгийн итгэлцэл татсан байна).
Гүйлгээ	4.0	Гүйлгээний дүн харьцангуй өндөр, гэхдээ дотооддоо хийгддэг
Харилцагч	4.0	Гадаад, дотоодын цөөн тооны мөнгөтэй харилцагч үйлчлүүлдэг.
Хүргэх суваг	3.0	Харилцагчтай нүүр тулж харилцдаг хэдий ч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд эрсдэл өндөртэй.
Дундаж оноо	**3.8**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	4.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дундаас дээш. Итгэлцэл татсан ББСБ-ын хувьд сөрөг нөлөө өндөртэй (2019 оны 2 дугаар улирлын байдлаар итгэлцэл татсан ББСБ-ын дунджаар өөрийн хөрөнгийн 79%-тай тэнцэх, дунджаар 3.5 тэрбум төгрөгийн итгэлцэл татсан байна).
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	3.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дунд зэрэг (харилцагчид арилжааны банкны хадгаламжид мөнгөө шилжүүлэх боломжтой)
Дундаж оноо	**3.5**	

Эрсдэлийн түвшин	**13.3**

8.1.8. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

Тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх (4.1.8)



Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах (1) шатанд харилцагчийг таньж мэдэхэд дараах зүйлсийг тусгайлан шалгах шаардлагатай. Үүнд:

1. Харилцагч нь улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл эсэх.
2. Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг эсэх.
3. Тухайн хүн, хуулийн этгээдийн эрхэлж буй ажил, үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн эх үүсвэрийг нягтлах.

Богино хугацаат хөрөнгө санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх (3) шатанд харилцагчийн зүгээс МУТС-тэй холбоотой дараах эрсдэл үүсэж болно.

1. Хөрөнгө оруулалтын ашигт төдийлөн ач холбогдол өгөхгүй бусад зүйлст тухайлбал, эргэн төлөгдөх хугацаа, нөхцөл, шат дараалал зэрэгт анхаарал хандуулах.
2. "Худалдан аваад шууд эргүүлээд хурдан зарагдах үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхол хийх сонирхол" илэрхийлэх.

3. Үнэт цаасны арилжаа зэрэг зохицуулалттай санхүүгийн хэрэгслээс бусад санхүүгийн хэрэгслийг илүүд үзэх.
4. Аль болох богино хугацаатай санхүүгийн хэрэгслийг сонгох.
5. Санхүүгийн хэрэгслийг гуравдагч этгээдийн нэр дээр бүртгүүлэх, шилжүүлэхээр тохиролцох.

Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаан дахь төрөлхийн эрсдэлийн хүчин зүйлс

Эмзэг байдлын үзүүлэлт	Эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс	Эрсдэлийг бууруулах хүчин зүйлс
Харилцагч	• Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), • МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, • НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл • Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг этгээд, • Харилцагчийн эрхэлж буй ажил, үйл ажиллагааны чиглэл нь хөрөнгийн эх үүсвэртэй холбоогүй, хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй	• Цөөн тооны тодорхой харилцагчтай • Харилцагч нь тусгайлан хяналт тавих этгээд биш (өмнөх нүдэнд дурдсан этгээд биш) • Хөрөнгийн эх үүсвэр тодорхой, харилцагчийн ажил, үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	• Харилцагчийн хөрөнгө нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө • Гэрээний хугацаа харьцангуй богино • Үнэт цаасаас бусад санхүүгийн хэрэгслийг санал болгодог.	• Харилцагчийн хөрөнгө нь бэлэн мөнгөнөөс бусад актив • Гэрээний хугацаа харьцангуй урт • Үнэт цаас зэрэг зохицуулалттай санхүүгийн хэрэгслийг санал болгодог
Хүргэх арга, хэлбэр	• Гэрээг гуравдагч этгээдээр дамжуулан хийх боломжтой	• Гэрээг гуравдагч этгээдээр дамжуулан хийх боломжгүй
Газар зүйн байршил	• Харилцагч нь гадаад улсаас эсвэл өөр байршлаас харилцаж байгаа • Салбар, төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг	• Харилцагч болон ББСБ нэг улс, байрлалд байгаа

Бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, комплеансын үзүүлэлтийн хувьд нийтлэг байдлаар авч үзэх хэрэгтэй (БҮЛЭГ 3-ыг үзнэ үү).

ББСБ-ын богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

10 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ	**1** ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна

** 2018 оны 2 дугаар улирлын байдлаар, Эх үүсвэр: СЗХ-ны ББСБ-ын газар.

ББСБ-ын богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	2.0	Цөөн тооны байгууллага ажилладаг (10 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй).
Бүтээгдэхүүн үйлчилгээ	3.0	Үйлчилгээний хувьд нарийн төвөгтэй байх боломжтой хэдий ч одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага.
Гүйлгээ	1.0	Одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага.
Харилцагч	1.0	Одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага.
Хүргэх суваг	1.0	Харилцагчтай нүүр тулж харилцдаг.
Дундаж оноо	**1.6**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	2.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө дундаас доош. Одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага.
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	2.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дундаас доош Одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага хэдий ч цаашид энэ төрлийн үйлчилгээ идэвжихэд сөрөг нөлөөтэй.
Дундаж оноо	**2.0**	

Эрсдэлийн түвшин	**3.2**

8.1.9. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ эрхлэгч ББСБ

Үйл ажиллагааны тодорхойлолт – МУТС төрөлхийн эрсдэл

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4.1.9-д заасны дагуу санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол хуулийн дагуу МэҮЭ болох бөгөөд МэҮЭ-ийн хүлээх бүх үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд:

a. Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
b. Харилцагчийн хөрөнгийг удирдах;
c. Банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
d. Компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
e. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

Энэ тохиолдолд МУТСТ тухай хуулийн 19.1-д "хуулийн 4.1.9-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллага эрсдэлд суурилсан хэлбэрээр тус тус хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу СЗХ-ноос хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

СЗХ-ноос хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ-уудын хувьд зээл, факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зэрэг үйлчилгээг давхар эрхэлж байгаа учраас эдгээр үйл ажиллагаатай уялдаатайгаар харилцагчийн хөрөнгийг удирдах зөвлөх үйлчилгээг үзүүлэх боломжтой. Энэ тохиолдолд МэҮЭ-ийн зүгээс тусгайлан хяналт тавих шаардлагатай.

ББСБ-аас харилцагчдад зориулж хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг төлбөртэйгөөр үзүүлэх тохиолдолд "хаалгачийн" үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ үүргээ биелүүлэхгүй байх буюу харилцагчид үндэслэлгүй дүгнэлт, зөвлөмж өгөх үйлдэхүй, МУТС-тэй холбоотой зөрчил дутагдлыг мэдсээр байж нуун дарагдуулах эс үйлдэхүйн эрсдэл үүсэх магадлалтай. Үүнийг зохицуулахын тулд зөвлөх үйлчилгээний мэргэжлийн ёс зүйн дүрэм, журмыг боловсруулан, хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай зэрэг үндэсний хууль тогтоомжийг удирдлага болгох хэрэгтэй.

Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд

32 ББСБ зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	**2** ББСБ тайлант хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлж орлого олсон	**118.7 сая** төгрөг Зөвлөх үйлчилгээний орлого

** 2018 оны 2 дугаар улирлын байдлаар, Эх үүсвэр: СЗХ-ны ББСБ-ын газар.

ББСБ-ын хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааны эрсдэлийн өнөөгийн түвшин

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлалын оноо	Тайлбар
Салбарын хэмжээ	2.0	Зөвлөх үйлчилгээний салбар харьцангуй сул хөгжсөн (2019 оны 2 дугаар улирлын байдлаар 32 ББСБ зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хэдий 2 ББСБ энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж орлого олжээ).
Бүтээгдэхүүн үйлчилгээ	1.0	МУТС-д шууд ашиглагддаггүй.
Гүйлгээ	1.0	МУТС-д шууд ашиглагддаггүй.
Харилцагч	1.0	МУТС-д шууд ашиглагддаггүй.
Хүргэх суваг	1.0	МУТС-д шууд ашиглагддаггүй.
Дундаж оноо	**1.2**	

Үр нөлөө	Үр нөлөөний оноо	Тайлбар
Санхүү – эдийн засгийн үр нөлөө	1.0	Санхүү-эдийн засгийн үр нөлөө бага. Одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага.
Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө	2.0	Нэр хүнд – итгэлцлийн үр нөлөө дундаас доош Одоогоор энэ төрлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо бага хэдий ч цаашид энэ төрлийн үйлчилгээ идэвжихэд сөрөг нөлөөтэй.
Дундаж оноо	**1.5**	

Эрсдэлийн түвшин	**1.8**